

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР

**МОНГОЛ УЛСЫН НЭГДСЭН ТӨСВИЙН
2026 ОНЫ ТӨСВИЙН ХҮРЭЭНИЙ МЭДЭГДЭЛ,
2027-2028 ОНЫ ТӨСВИЙН ТӨСӨӨЛЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД
ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСӨЛ**



УЛААНБААТАР ХОТ

2025 ОН

АГУУЛГА

1. НЭГДҮГЭЭР БҮЛЭГ. МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ	3
1.1. Монгол Улсын эдийн засгийн 2025 оны эхний хагас жилийн гүйцэтгэл	3
1.1.1. Дотоодын нийт бүтээгдэхүүн	3
1.1.2. Хэрэглээний үнийн түвшин, мөнгөний бодлогын үндсэн үзүүлэлт	4
1.1.3. Ажил эрхлэлт, ажилгүйдлийн түвшин	5
1.1.4. Нэгдсэн төсөв	6
1.1.5. Гадаад худалдааны тэнцэл	7
1.1.6. Төлбөрийн тэнцэл	7
1.2. Монгол Улсын эдийн засгийн 2025 оны хүлээгдэж буй гүйцэтгэл.....	8
1.2.1. Дотоодын нийт бүтээгдэхүүн	8
1.2.2. Хэрэглээний үнийн түвшин, мөнгөний бодлогын үндсэн үзүүлэлт	9
1.2.3. Ажил эрхлэлт, ажилгүйдлийн түвшин	9
1.2.4. Нэгдсэн төсөв	9
1.2.5. Гадаад худалдааны тэнцэл	10
1.2.6. Төлбөрийн тэнцэл	11
2. ХОЁРДУГААР БҮЛЭГ. МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТҮҮДИЙН ДУНД ХУГАЦААНЫ ТӨСӨӨЛӨЛ	12
2.1. Монгол Улсын эдийн засгийн 2026-2028 оны төсөөлөл	12
2.1.1. Дэлхийн эдийн засгийн төлөв.....	12
2.1.2. Уул уурхайн бүтээгдэхүүний зах зээлийн хандлага.....	13
2.1.3. Дотоодын нийт бүтээгдэхүүн	15
2.1.4. Хэрэглээний үнийн түвшин, мөнгөний бодлогын үндсэн үзүүлэлт	15
2.1.5. Ажил эрхлэлт, ажилгүйдлийн түвшин	16
2.1.6. Гадаад худалдааны тэнцэл	16
2.1.7. Төлбөрийн тэнцэл	17
2.2. Нэгдсэн төсвийн үндсэн үзүүлэлтүүдийн 2026-2028 оны төсөөлөл	18
2.2.1. Төсвийн тэнцвэржүүлсэн орлогын төсөөлөл	18
2.2.2. Төсвийн нийт зарлагын хэмжээ, түүний өсөлт	19
2.2.3. Нэгдсэн төсвийн суурь зарлагын дээд хэмжээ	20
2.2.4. Төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл.....	20
3. ГУРАВДУГААР БҮЛЭГ. МОНГОЛ УЛСЫН 2026 ОНЫ ТӨСВИЙН ХҮРЭЭНИЙ МЭДЭГДЭЛ, 2027-2028 ОНЫ ТӨСВИЙН ТӨСӨӨЛЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ТАЛААР	21
3.1. Дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэл өөрчлөх үндэслэл	21
3.2. Дунд хугацаанд баримтлах төсвийн бодлого	21
3.3. Төсвийн тусгай шаардлага хангасан байдал.....	24

3.4. Монгол Улсын нэгдсэн төсвийн 2026 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2027-2028 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл	26
4. ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ. МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН ТУЛГАРЧ БОЛЗОШГҮЙ ЭРСДЭЛ	27
5. ХАВСРАЛТ	29
5.1. Олон нийтийн хэлэлцүүлгийн үр дүн.....	29

ХҮСНЭГТ

Хүснэгт 1.1 ДНБ-ий өсөлтийн бүтэц, салбаруудаар (хувь)	3
Хүснэгт 1.2 Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлого (тэрбум төгрөг)	9
Хүснэгт 1.3 Төсвийн нийт зарлагын хэмжээ, түүний өсөлт (тэрбум төгрөг)	10
Хүснэгт 1.4 Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл, түүний гүйцэтгэл (ДНБ-д эзлэх хувь).....	10
Хүснэгт 3.1 Дэлхийн эдийн засгийн өсөлтийн төсөөлөл	12
Хүснэгт 3.2 Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлогын төсөөлөл (тэрбум төгрөг)	18
Хүснэгт 3.3 Нэгдсэн төсвийн нийт зарлагын төсөөлөл (тэрбум төгрөг)	19
Хүснэгт 3.4 Нэгдсэн төсвийн суурь зарлагын төсөөлөл (тэрбум төгрөг)	20
Хүснэгт 3.5 Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл (тэрбум төгрөг)	20
Хүснэгт 4.1 Нэгдсэн төсвийн суурь тэнцлийн төсөөлөл (ДНБ-д эзлэх хувь)	25
Хүснэгт 4.2 Засгийн газрын өрийн нэрлэсэн дүнгээр илэрхийлсэн үлдэгдлийн төсөөлөл (ДНБ-д эзлэх хувь)	25
Хүснэгт 4.3 Монгол Улсын нэгдсэн төсвийн 2026 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2027-2028 оны төсвийн төсөөллийн үзүүлэлт	26

ЗУРАГ

Зураг 1.1 ДНБ-ий өсөлтийн бүтэц, эрэлт талаас (хувь)	3
Зураг 1.2 Инфляц, мөнгөний нийлүүлэлт, зээлийн үлдэгдэл	5
Зураг 1.3 Ажил эрхлэлтийн үзүүлэлтүүд	6
Зураг 1.4 Гадаад худалдааны үзүүлэлт	7
Зураг 1.5 Төлбөрийн тэнцэл, гадаад валютын нөөц.....	8
Зураг 3.1 Дэлхийн тодорхой бус байдлын индекс	12
Зураг 3.2 Зэсийн үнийн хөдөлгөөн, төсөөлөл (ам.доллар/тонн)	14
Зураг 3.3 Алтны үнийн хөдөлгөөн, төсөөлөл (ам.доллар/унц)	14
Зураг 3.4 Нүүрсний үнийн хөдөлгөөн, төсөөлөл (ам.доллар/тонн)	14
Зураг 3.5 Төмрийн хүдрийн үнийн хөдөлгөөн, төсөөлөл (ам.доллар/унц)	14
Зураг 3.6 Газрын тосны үнийн хөдөлгөөн, төсөөлөл (ам.доллар/баррель	15

Хураангуй

Энэхүү дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдлийн төслийг Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.3 дахь хэсэгт заасны дагуу макро эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүдийн нөхцөл байдал, ирээдүйн чиг хандлага, төсөөлөл болон Засгийн газраас баримтлах дунд хугацааны төсвийн бодлого, макро эдийн засагт учирч болзошгүй эрсдэл гэсэн агуулга, бүтцээр бэлтгэлээ.

Дэлхийн эдийн засагт тодорхой бус нөхцөл байдал өндөр байгаа энэ цаг үед манай улсын экспортын гол бүтээгдэхүүн болох нүүрсний үнэ 2025 оны эхний 6 сард дунджаар 70 ам.доллар болж, өмнөх оны мөн үеэс 40 хувиар, нийт экспорт 2025 оны эхний 6 сард 6.6 тэрбум ам.доллар болж, өмнөх оны мөн үеэс 20 хувь буюу 1.3 тэрбум ам.доллараар, төсвийн нийт орлого 14.0 их наяд төгрөг болж, 6 хувь буюу 0.9 их наяд төгрөгөөр тус тус буураад байна. Цаашид дэлхий дахинд тодорхой бус байдал үргэлжлэх эрсдэл өндөр байгаагийн улмаас манай улсын эдийн засгийн нийт эрэлт саарах хандлага үргэлжлэх төлөвтэй байна.

Монгол Улсын төсвийн 2026 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2027-2028 оны төсвийн төсөөллийн тухай хуульд нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлогын доод хэмжээ болон нийт зарлагын дээд хэмжээг 33.4 их наяд төгрөг байхаар баталсан. Гэвч дэлхий дахинд бий болсон тодорхой бус байдал, түүнээс манай улсын эдийн засагт үзүүлж буй сөрөг нөлөөллийн улмаас 2026 оны төсвийн хүрээний мэдэгдэл дэх төсвийн тэнцвэржүүлсэн орлого, нийт зарлагын дүн хангагдахгүй байх эрсдэл үүсээд байна.

Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд 2025 оны 7 дугаар сарын 09-ний өдөр “Дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэлд нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлогын доод хэмжээ болон нийт зарлагын дээд хэмжээг нэгэн зэрэг бууруулах өөрчлөлт орсонтой холбогдуулан жилийн төсөв, төсвийн тодотголын төслийг Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх, батлахад энэ хуулийн 7.5-д заасан хязгаарлалт хамаарахгүй” байхаар нэмэлтээр тусган баталсан.

Дээр дурдсан нөхцөл байдал болон хууль, эрх зүйн орчинтой уялдуулан Монгол Улсын нэгдсэн төсвийн 2026 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2027-2028 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулж, Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн дагуу дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдлийн үндсэн үзүүлэлтүүд болон үзүүлэлтийн хэмжээг өөрчлөх шаардлагатай байна.

Монгол Улсын нэгдсэн төсвийн 2026 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2027-2028 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд эдийн засгийн бодит өсөлт 2026 онд 5.7 хувь, 2027 онд 6.3 хувь, 2028 онд 6.5 хувь байхаар, мөн инфляцыг төв банкны зорилтот интервал дотор байхаар тооцож, тусгалаа. Төсвийн бодлогын хувьд макро эдийн засгийн тогтвортой байдлыг хангах, эдийн засаг дахь төрийн оролцоог үе шаттай бууруулж, хувийн хэвшлийн бизнес тэлэх орон зайг нэмэгдүүлэх, эдийн засгийн салбаруудын бүтээмжийг дэмжих чиглэл баримтална.

Эдгээр бодлогуудын хүрээнд нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцлийг 2026 онд ДНБ-ий 1.3 хувьтай тэнцэх дүнгээр алдагдалтай баталж хэрэгжүүлэх, цаашид 2027, 2028 онд төсвийн бодлогын орон зайг тогтвортой хадгалах болон нэмэгдүүлэх зорилгоор нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцлийн алдагдлын дүнг үе шаттай бууруулахаар хуулийн төсөлд тусгав. Мөн төсвийн тэнцвэржүүлсэн орлого болон нэрлэсэн ДНБ-ий харьцаа 2023 онд 33 хувь, 2024 онд 37 хувь болж нэмэгдээд байсныг 2026 онд 30.9 хувь, 2027 онд 29.3 хувь, 2028 онд 28.2 хувь болгох үе шаттай бууруулахаар хуулийн төсөлд тусгалаа. Ингэснээр хувийн хэвшлийг дэмжсэн татварын шинэчлэл хийгдэх орон зайг болгож, хувийн хэвшлийн бизнесийн тэлэх боломжийг бүрдүүлэх, улмаар эдийн засаг дахь төрийн оролцоог үе шаттай бууруулна.

1. Нэгдүгээр бүлэг. Макро эдийн засгийн нөхцөл байдал

Макро эдийн засгийн нөхцөл байдлыг Монгол Улсын эдийн засгийн 2025 оны эхний хагас жилийн гүйцэтгэл, Монгол Улсын эдийн засгийн 2025 оны хүлээгдэж буй гүйцэтгэл гэсэн агуулгаар боловсруулж бэлтгэлээ.

1.1. Монгол Улсын эдийн засгийн 2025 оны эхний хагас жилийн гүйцэтгэл

Энэ дэд бүлэгт макро эдийн засгийн үзүүлэлтүүдийн нөхцөл байдлыг хамгийн сүүлийн үеийн албан статистик тоон мэдээлэлд үндэслэн боловсруулж бэлтгэв.

1.1.1. Дотоодын нийт бүтээгдэхүүн

Нэрлэсэн дотоодын нийт бүтээгдэхүүн (ДНБ) 2025 оны эхний хагас жилд 40.3 их наяд төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеэс 8.8 хувиар, 2015 оны зэрэгцүүлэх үнээр тооцсон бодит ДНБ 15.3 их наяд төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 5.6 хувиар тус тус өслөө.

Хүснэгт 1.1 ДНБ-ий өсөлтийн бүтэц, салбаруудаар (хувь)

Салбар	2021	2022	2023	2024	2025.II
ДНБ	1.6	5.0	7.4	5.1	5.6
ХАА	-0.8	1.7	-1.3	-3.6	3.6
Үйлдвэрлэл	-0.6	-1.2	3.2	1.6	1.2
Уул уурхай	0.1	-2.1	2.6	1.4	0.1
Боловсруулах	-0.1	0.5	0.4	-0.3	0.3
Цахилгаан, ус	0.2	0.1	0.1	0.1	0.3
Барилга	-0.9	0.2	0.1	0.4	0.4
Үйлчилгээ	1.8	3.2	4.7	5.4	0.7
Худалдаа	0.6	1.1	0.8	1.4	-0.7
Тээвэр	-0.3	0.4	1.8	1.0	-0.6
Бусад	1.5	1.7	2.1	2.5	1.4
Цэвэр татвар	1.3	1.4	0.8	1.8	0.2

Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

Зураг 1.1 ДНБ-ий өсөлтийн бүтэц, эрэлт талаас (хувь)



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

Хөдөө аж ахуйн салбарын сэргэлт эдийн засгийн өсөлтийг дэмжиж байгаа бол уул уурхайн салбарын өсөлт удааширч, тээвэр, худалдааны салбарууд агшиж, өсөлтийг сааруулав.

Уул уурхайн салбар дах зэсийн баяжмалаас бусад бүтээгдэхүүний үйлдвэрлэл буурснаар өсөлтийн эрчим өнгөрсөн оноос саарч, 1.1 хувьд хязгаарлагдлаа. Тухайлбал, нүүрс олборлолт 43.8 сая тонн болж, өмнөх оны мөн үеэс 11 хувиар, төмрийн хүдэр, баяжмал үйлдвэрлэл 4.8 сая тонн болж, өмнөх оны мөн үеэс 5 хувиар тус тус буурлаа. Түүнчлэн 2025 оны эхний хагас жилд газрын тос олборлолт 1.9 сая баррель, алтны олборлолт 4.5 тонн болж буурсан байна. Харин Оюу толгойн зэсийн баяжмалын үйлдвэрлэл нэмэгдсэнээр нийт зэсийн баяжмал үйлдвэрлэл 29 хувиар өсөж 970 мянган тоннд хүрч, уул уурхайн салбарын өсөлтийг дэмжлээ.

Уул уурхайн бус салбарын өсөлт 2025 оны эхний хагас жилд хөдөө аж ахуйн салбарын сэргэлтийн голлох нөлөөгөөр эрчимжиж, 6.3 хувьд хүрлээ. Хаваржилт тогтуун байж, мал төллөлт, бойжилт хэвийн үргэлжилсний үр дүнд бойжсон төлийн

тоо толгой 20.8 саяд хүрч (төл бойжилт 98.5 хувь) өмнөх оны мөн үеэс 5.4 сая толгой малаар нэмэгдэн, том малын зүй бус хорогдол 189 мянга болж, өмнөх оны мөн үеэс 7.9 сая толгой малаар буурсан голлох нөлөөгөөр хөдөө аж ахуйн салбар 36 хувиар өсөж, эдийн засгийн өсөлтийн 3.6 нэгж хувийг бүрдүүллээ. Барилгын салбар 2025 оны эхний хагас жилд орон сууц, эмнэлэг, сургууль, цэцэрлэгийн барилга, байгууламж болон Багахангай-Хөшигийн хөндий чиглэлийн төмөр замын бүтээн байгуулалтын ажлын голлох нөлөөгөөр 25 хувиар өсөж, өсөлтийг 0.4 нэгж хувиар дэмжлээ. Мөн шинээр ашиглалтад орсон Тосон, Бөөрөлжүүт зэрэг ДЦС-уудын үйлдвэрлэлийн нөлөөгөөр цахилгаан эрчим хүч үйлдвэрлэл 4.8 тэрбум кВт цагт хүрч өмнөх оны мөн үеэс 9 хувиар, дулааны эрчим хүч үйлдвэрлэл 9.5 сая.Гкалд хүрч 7.7 хувиар өссөнөөр эрчим хүчний салбар үйлдвэрлэл 8.4 хувиар тэлж, эдийн засгийн өсөлтийг 0.3 хувиар дэмжлээ. Харин авто тээврийн орлогын бууралтын голлох нөлөөгөөр тээврийн салбар 2025 оны эхний хагас жилд 12.5 хувиар агшиж, эдийн засгийн өсөлтийг 0.6 нэгж хувиар сааруулав. Мөн бөөний болон жижиглэн худалдааны салбар 5.7 хувиар агшлаа.

Нийт эрэлтийн талаас авч үзвэл эдийн засгийн өсөлт 2025 оны эхний хагас жилд үндсэн хөрөнгийн хуримтлал, өрхийн хэрэглээний өсөлтийн голлох нөлөөгөөр 5.7 хувьд хүрч, өмнөх оны мөн үеийн орчимд хадгалагдлаа. Хаврын цаг агаар таатай байж том малын зүй бус хорогдол бага, төл бойжилт өндөр байсны үр дүнд биологийн өсөж үрждэг хөрөнгө нэмэгдсэний голлох нөлөөгөөр үндсэн хөрөнгийн хуримтлал өмнөх оны мөн үеэс 18.6 хувиар өсөж, нийт эрэлтийн өсөлтийг 6.5 нэгж хувиар дэмжлээ. Мөн орон сууц, эмнэлэг, сургууль, цэцэрлэг зэрэг орон сууцны бус барилгын бүтээн байгуулалтын ажил үндсэн хөрөнгийн хуримтлалыг дэмжсэн байна. Өрхийн хэрэглээ 2025 оны эхний хагас жилд өрхийн бодит орлого өмнөх оны мөн үеэс 8.0 хувиар, хэрэглээний зээл 19.6 хувиар тус тус өссөний голлох нөлөөгөөр 9.9 хувиар өсөж, нийт өсөлтийг 7.8 нэгж хувиар дэмжээ. Харин зэсээс бусад уул уурхайн бүтээгдэхүүний экспорт буурсан хэдий ч барааны импортын өсөлт саарсан нь нийт эдийн засгийн өсөлтөд үзүүлэх цэвэр экспортын сөрөг нөлөөг бууруулсан байна.

1.1.2. Хэрэглээний үнийн түвшин, мөнгөний бодлогын үндсэн үзүүлэлт

Улсын жилийн инфляц 2025 оны 7 дугаар сард 8.1 хувь болж, өмнөх оны мөн үеэс 3.0 нэгж хувиар өсөж, өмнөх сараас 0.1 нэгж хувиар буурлаа. Инфляц өмнөх оны мөн үеэс өсөхөд мах, цахилгааны төлбөр, орон сууцны түрээс, машин болон нийтийн тээврийн үйлчилгээ, хувцасны бүлгийн үнийн өсөлт голчлон нөлөөлжээ.

Импортын барааны үнэ 2025 оны 7 дугаар сард өмнөх оны мөн үеэс 4.3 хувиар өсөж, нийт инфляцын 2.1 нэгж хувь буюу 26.1 хувийг бүрдүүлсэн байна. Импортын барааны үнийн өсөлтийн дийлэнхийг хүнсний бус бараа бүрдүүлж байна.


Дотоодын бараа, үйлчилгээний үнэ өмнөх оны мөн үеэс 11.5 хувиар өсөж, нийт инфляцын 6.0 нэгж хувь буюу 73.9 хувийг бүрдүүллээ. Хүнсний барааны үнэ 2025 оны 7 дугаар сард 6.4 хувиар өссөн нь нийт инфляцын 1.8 нэгж хувийг бүрдүүлэв. Үүний 1.5 нэгж хувийг дотоодын хүнсний бүтээгдэхүүн бүрдүүллээ. Хүнсний үнийн өсөлтийн дийлэнх буюу 80 орчим хувийг талх, нарийн боов, сүү, мах, махан бүтээгдэхүүний үнийн өсөлт тайлбарлаж байна.

Хүнсний бус бараа, үйлчилгээний үнэ өмнөх оны мөн үеэс 8.8 хувиар өсөж, нийт инфляцын 6.3 нэгж хувийг эзэлж байна. Үүнд хувцас, бөс бараа, гутлын бүлгийн үнэ өмнөх оны мөн үеэс 9.1 хувиар, өрхийн цахилгааны төлбөр 65 хувиар, автобусны билетийн үнэ 100 хувиар, орон сууцны түрээс 40.3 хувиар тус тус өссөн нь голлон нөлөөлөв.

Хүнс, шатахуун, хатуу түлш, болон эрчим хүчний нөлөөг хасаж тооцсон эрэлтийн гаралтай (суурь) инфляц 2025 оны 7 дугаар сард 8.2 хувь гарч, өмнөх оны мөн үеэс 2.8 нэгж хувиар эрчимжсэн хэдий ч сүүлийн 4 сар дараалан буурч байна. Эрэлтийн инфляц саарахад эдийн засгийн дотоод идэвхжил суларсан нь нөлөөллөө. Эрэлтийн шалтгаантай инфляц нийт инфляцын дийлэнх буюу 62 орчим хувийг тайлбарлаж байна. Нийлүүлэлтийн гаралтай инфляц 2025 оны 7 дугаар сард 7.9 хувьд хүрч, өмнөх оны мөн үеэс 3.5 нэгж хувиар эрчимжив. Үүнд цахилгааны тариф нэмэгдсэн болон малын зүй бус хорогдолтой холбоотойгоор махны үнэ өссөн нь нөлөөллөө.

Мөнгөний нийлүүлэлт 2025 оны 7 дугаар сарын байдлаар 43.1 их наяд төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеэс 3.2 хувиар өслөө. Мөнгөний нийлүүлэлтийн өсөлтөд эх үүсвэр (пассив) талаас төгрөг ба гадаад валютын хадгаламж нийлбэр дүнгээр 15.8 хувиар өссөн нь голлон нөлөөлсөн бол төгрөг ба гадаад валютын харилцах нийлбэр дүнгээр өмнөх оны мөн үеэс 15.7 хувиар буурч, өсөлтийг сааруулжээ. Харин мөнгөний нийлүүлэлтийн байршуулалт (актив) талаас гадаад цэвэр актив жилийн өсөлтийн - 9.8 нэгж хувийг, дотоод цэвэр актив 13.0 нэгж хувийг тус тус бүрдүүлсэн байна. Зээлийн өсөлт өндөр хэвээр хадгалагдсан нь дотоод цэвэр активыг нэмэгдүүлсэн байна.

Зураг 1.2 Инфляц, мөнгөний нийлүүлэлт, зээлийн үлдэгдэл




1.1.3. Ажил эрхлэлт, ажилгүйдлийн түвшин

Ажиллагчдын тоо 2025 оны эхний хагасын байдлаар өмнөх оны мөн үеэс 43 мянгаар нэмэгдэж 1 сая 390 мянгад хүрсэн байна. Энэхүү өсөлтөд нийт ажиллагчдын дөрөвний нэгийг бүрдүүлдэг хөдөө аж ахуйн салбарын ажиллагчдын тоо сэргэж, өмнөх оны мөн үеэс 45 мянгаар буюу 14 хувиар өссөн нь голчлон нөлөөллөө. Мөн барилгын салбарт 15 мянга, уул уурхай, боловсруулах салбарт тус бүр 11 мянган ажилчид нэмэгдсэн нь өсөлтийг дэмжлээ. Харин үйлчилгээний

салбарын ажилчид 27 мянгаар, худалдааны салбар 19 мянгаар буурсан нь өсөлтийн хурдыг сааруулсан байна.

Зураг 1.3 Ажил эрхлэлтийн үзүүлэлтүүд



Харин ажилгүй иргэдийн тоо өмнөх оны мөн үеэс 16 мянган хүнээр буюу 20 хувиар буурч 66 мянгад хүрлээ. Ингэснээр ажилгүйдлийн түвшин 1.2 нэгж хувиар буурч 4.5 хувьд хүрэв. Энэхүү бууралт нь ажиллах хүчний өсөлтийг сааруулснаар ажиллах хүчний оролцооны түвшин өмнөх оны мөн үеэс 0.3 нэгж хувиар буурч 61.9 хувь болсон байна.

1.1.4. Нэгдсэн төсөв

Монгол Улсын нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлого 2025 оны эхний 7 сарын байдлаар 16,578.3 тэрбум төгрөгт хүрч өмнөх оны мөн үеэс 1,071.2 тэрбум төгрөг буюу 6.1 хувиар буурч, төлөвлөсөн хэмжээнээс 5.8 хувиар буюу 1,017.2 тэрбум төгрөгөөр дутуу биелсэн гүйцэтгэлтэй гарлаа. Түүхий эдийн үнийн уналтаас шалтгаалан төсвийн орлого төвлөрүүлэлтэд сөргөөр нөлөөлсөн байна. Тухайлбал, ААНОАТ өмнөх оны мөн үеэс 1,137.4 тэрбум төгрөг буюу 27.7 хувиар, АМНАТ-ийн нийт орлого 1,192.1 тэрбум төгрөг буюу 39.4 хувиар тус тус буурчээ.

Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн 2025 оны эхний 7 сарын байдлаар 16,887.6 тэрбум төгрөгт хүрч өмнөх оны мөн үетэй харьцуулахад 10.7 хувиар, урсгал зардал 14,133.3 тэрбум төгрөгт хүрч 16.6 хувиар тус тус өссөн хэдий ч төлөвлөсөн хэмжээнээс нийт зарлага ба цэвэр зээлийн дүн 14.4 хувиар, урсгал зардал 9.0 хувиар буурсан гүйцэтгэлтэй байна. Нэгдсэн төсвийн хөрөнгө оруулалтын гүйцэтгэл 2025 оны эхний 7 сарын байдлаар байдлаар 2,701.8 тэрбум төгрөг буюу 31.8 хувьтай байна.

Нүүрсний үнийн уналт төсвийн орлогыг бууруулснаар 2025 оны эхний 7 сарын байдлаар Монгол улсын нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл 1,299.3 тэрбум төгрөгийн алдагдалтай гарч, өмнөх оноос 2,872.8 тэрбум төгрөгөөр буурсан байна.

Засгийн газрын өрийн нэрлэсэн үлдэгдэл 2025 оны эхний хагас жилийн байдлаар 35.5 их наяд төгрөгт буюу ДНБ-д эзлэх хувь 39.5 хувьд хүрч, өмнөх оны мөн үеэс 17.5 хувиар өссөн байна.

1.1.5. Гадаад худалдааны тэнцэл

Гадаад худалдааны нийт бараа эргэлт 2025 оны эхний 7 сард 14.2 тэрбум ам.долларт хүрч, худалдааны тэнцэл 1.3 тэрбум ам.долларын ашигтай гарлаа. Экспорт 2025 оны эхний 7 сард 7.8 тэрбум ам.долларт хүрч, өмнөх оны мөн үеэс 16.3 хувиар буурлаа.

Экспортын орлого өмнөх оны мөн үеэс буурахад нүүрсний хилийн үнэ тонн тутамдаа 68.0 ам.доллар болж, өмнөх оны мөн үеэс 40.4 хувиар, нүүрсний экспортын биет хэмжээ 44.4 сая тоннд хүрч, өмнөх оны мөн үеэс 6.6 хувиар тус тус буурсан нь голлон нөлөөллөө. Харин зэсийн баяжмалын экспорт нэмэгдсэн байна. Далд уурхайн олборлолтын үйл ажиллагаа тогтворжсон, дэлхийн зах зээлд цэвэр зэсийн эрэлт өндөр түвшинд хадгалагдсан зэргээс шалтгаалан зэсийн баяжмалын экспорт 1,243 мянган тоннд хүрч, өмнөх оны мөн үеэс 34.0 хувиар өсжээ. Мөн төмрийн хүдрийн экспорт 4,681 мянган тоннд хүрч, 10.0 хувиар нэмэгдсэн байна.

Уул уурхайн бус экспортын хувьд Засгийн газрын шийдвэрээр угаасан ноолуурын экспортыг хязгаарласантай холбоотойгоор 2025 оны хоёрдугаар улиралд ноолуурын экспорт 76 хувиар буурсан байна. Үүнээс гадна, боловсруулах үйлдвэрлэлийн идэвх сул байсан нь мах болон арьс, ширний экспорт буурахад нөлөөлсөн байна.

Зураг 1.4 Гадаад худалдааны үзүүлэлт



Эх сурвалж: Гаалийн ерөнхий газар

Тэмдэглэл: Импортын бараа, бүтээгдэхүүнийг хэрэглээний зориулалтаар ангилав.


Нийт импорт 2025 оны эхний 7 сарын байдлаар 6.5 тэрбум ам.долларт хүрч, жилийн өсөлтийн хурд 1.1 хувьд хүрч саарлаа. Хэрэглээний бүтээгдэхүүний импорт өмнөх оны мөн үеэс 14 хувиар өссөн бол аж үйлдвэрийн орцын импорт 10 хувиар, хөрөнгө оруулалтын бүтээгдэхүүний импорт 3 хувиар тус тус буурсан байна. Хэрэглээний бүтээгдэхүүний импортын өсөлтөд суудлын автомашин болон хүнсний бүтээгдэхүүний импорт голлох нөлөөг үзүүллээ. Тухайлбал, суудлын автомашины импорт 2025 оны эхний 7 сард 753 сая ам.долларт хүрч, өмнөх оны мөн үеэс 33 хувь буюу 187 сая ам.доллараар, хүнсний бүтээгдэхүүний импорт 682 сая ам.долларт хүрч, өмнөх оны мөн үеэс 9 хувь буюу 55 сая ам.доллараар тус тус нэмэгдсэн байна.

1.1.6. Төлбөрийн тэнцэл

Төлбөрийн тэнцэл 2025 оны эхний 6 сарын байдлаар 462 сая ам.долларын алдагдалтай гарлаа. Төлбөрийн тэнцэл өмнөх оны мөн үеэс буурахад нүүрсний

үнийн уналтаас шалтгаалан Бараа, үйлчилгээний экспорт өмнөх оны мөн үеэс 970 сая ам.доллараар буурсан нь голлон нөлөөллөө. Гадаад валютын улсын нөөц 2025 оны эхний хагас жилийн эцэст 5,206 сая ам.долларт хүрч, өмнөх оны эцэстэй харьцуулахад 304 сая ам.доллараар буурлаа. Засгийн газраас экспортын орлого, санхүүгийн дансны ашгийг нэмэгдүүлж, гадаад валютын улсын нөөцийг өсгөхөд чиглэсэн арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлж байна.

Зураг 1.5 Төлбөрийн тэнцэл, гадаад валютын нөөц



Эх сурвалж: Монголбанк

1.2. Монгол Улсын эдийн засгийн 2025 оны хүлээгдэж буй гүйцэтгэл

Энэ дэд бүлэгт дотоодын нийт бүтээгдэхүүн, ажил эрхлэлт, ажилгүйдэл, нэгдсэн төсвийн үзүүлэлтүүд болох тэнцвэржүүлсэн орлого, нийт зарлага, тэнцвэржүүлсэн тэнцэл, мөн гадаад худалдаа болон төлбөрийн тэнцлийн 2025 оны хүлээгдэж буй гүйцэтгэлийг боловсруулж харуулав.

1.2.1. Дотоодын нийт бүтээгдэхүүн

Эдийн засгийн өсөлтийг 2025 оны эцэст 5.5 хувь байхаар төсөөлж байна. Салбаруудаар авч үзвэл, байгаль, цаг уурын таатай байдлын нөлөөгөөр төл бойжилт өндөр, том малын зүй бус хорогдол бага байж, хөдөө аж ахуйн салбар эдийн засгийн өсөлтийг голлон тэтгэх төлөвтэй байна. Нүүрс олборлолтын эрчим удааширч, уул уурхайн салбарын өсөлтийн хурд саарах хандлагатай байгаа ч Оюу толгойн гүний уурхайн олборлолтын нөлөөгөөр баяжмал дахь зэс болон алтны агуулга нэмэгдэж, уул уурхайн салбарын өсөлтийг дэмжих хүлээлттэй байна. Барилгын салбарын өсөлт нь Багахангай-Хөшигийн хөндий чиглэлийн төмөр зам, орон сууц, орон сууцны бус барилгын бүтээн байгуулалтын нөлөөгөөр эрчимжиж, эдийн засгийн өсөлтийг дэмжинэ. Хөдөө аж ахуй болон уул уурхайн салбарын үйл ажиллагааны идэвхжилийн нөлөөгөөр боловсруулах салбарын өсөлт эдийн засгийн өсөлтөд эерэг нөлөө үзүүлэх төлөвтэй байна.

Нийт эрэлтийн талаас дотоод эрэлтийн эдийн засгийн өсөлтөд үзүүлэх нөлөө хадгалагдах хэдий ч 2024 оны түвшнээс сулрах хүлээлттэй байна. Дотоод эрэлтийг үндсэн хөрөнгийн хуримтлал голлон дэмжинэ. Харин цалингийн өсөлт саарч, хэрэглээний зээлийн нөхцөл чангарснаар өрхийн хэрэглээний өсөлт аажмаар хумигдах төлөвтэй байна. Нүүрс, газрын тосны экспорт буурсан ч, импортын өсөлт нам түвшинд хадгалагдсанаар цэвэр экспортын эдийн засгийн өсөлтөд үзүүлэх сөрөг нөлөө буурахаар хүлээгдэж байна.

1.2.2. Хэрэглээний үнийн түвшин, мөнгөний бодлогын үндсэн үзүүлэлт

Инфляц 2025 онд дунджаар төв банкны зорилтот түвшний орчимд байх төлөвтэй байна. Цахилгааны тарифын нэмэгдлийн нөлөөгөөр дотоодын бараа, үйлчилгээний үнэ өсөх хандлагатай байсны зэрэгцээ эрэлтийн гаралтай инфляц өндөр байсан бол 2025 оны сүүлээс саарч, тогтворжих хүлээлттэй байна. Цаашид геополитикийн хурцадмал байдал, уур амьсгалын өөрчлөлт, тээвэр логистикийн саатлаас үүдэн инфляц өдөөгдөх эрсдэлүүд хадгалагдаж байна.

1.2.3. Ажил эрхлэлт, ажилгүйдлийн түвшин

Хөдөлмөрийн насны хүн амын хувьд 1990-2005 онд төрөлтийн түвшин бага байснаас шалтгаалж одоо үеийн залуу боловсон хүчин болох 20-34 насны залуучуудын тоонд нөлөө үзүүлж байгаа нь хөдөлмөрийн нийлүүлэлтийн өсөлтийг сааруулах хүчин зүйл болж байна. Үүний улмаас ажил эрхлэлтийн үзүүлэлтүүдийн өсөлтийн хурд буурах хандлагатай байна.

Ажилчдын тоо 2025 онд 33 мянгаар буюу 2.4 орчим хувиар нэмэгдэж 1 сая 388 мянгад хүрэх төлөвтэй байна. Уг өсөлтөд хөдөө аж ахуйн салбарын сэргэлтийн нөлөөгөөр салбарын ажилчдын тоо нэмэгдэх хүлээлттэй байгаа нь нийт ажил эрхлэлтийн өсөлтийг дэмжихээр байна.

Түүнчлэн хөдөлмөрийн эрэлтийн өсөлт, хөдөлмөр эрхлэх хандлага нэмэгдсэнтэй холбоотойгоор ажиллах хүч 33 мянган хүнээр буюу 2 орчим хувиар нэмэгдэж 1 сая 474 мянгад хүрэх төлөвтэй байна. Үүний үр дүнд ажиллах хүчний оролцооны түвшин өмнөх оноос 0.5 нэгж хувиар өсөж, 2025 онд 61.8 хувьд хүрнэ гэж үзэж байна. Нөгөөтээгүүр ажилгүй иргэдийн тоо өмнөх оноос 1 мянгаар өсөж, 86 мянгад хүрч, ажилгүйдлийн түвшин 5.8 хувь орчимд хүрэх хүлээлттэй байна.

1.2.4. Нэгдсэн төсөв

Дэлхийн тодорхой бус байдал, худалдааны дайнаас шалтгаалан нүүрсний үнэ буурч буйтай холбоотойгоор уул уурхай олборлох салбар болон түүнийг дагасан тээвэр, худалдааны салбаруудын өсөлтийг сааруулж нэгдсэн төсвийн орлогын төвлөрүүлэлтэд сөргөөр нөлөөлж байна. Эдийн засгийн нөхцөл байдалтай уялдуулан Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуульд нэгдсэн төсвийн нийт орлогын хэмжээг 32,540.2 тэрбум төгрөг, тэнцвэржүүлсэн орлого ба тусламжийн дүнг 30,209.9 тэрбум төгрөг тус тус байхаар тодотгон баталсан.

Хүснэгт 1.2 Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлого (тэрбум төгрөг)

Үзүүлэлт	2024 Гүйц	2025 Тод	Зөрүү
Тэнцвэржүүлсэн орлого	29,670.8	30,209.9	593.1
ДНБ-д эзлэх хувь	33.1%	33.6%	

Эх сурвалж: Сангийн яам

2025 оны төсвийн тодотголын хүрээнд нэгдсэн төсвийн нийт зарлагын дүнг 31,573.9 тэрбум төгрөг буюу батлагдсан дүнгээс 1,857.6 тэрбум төгрөгөөр бууруулан баталсан бөгөөд дэлхийн зах зээл дээрх түүхий эдийн үнийн уналтаас шалтгаалан төсвийн орлого буурч байгаатай холбоотойгоор цаашид төсвийн зардлыг танах хэрэгцээ, шаардлага үүсэж байна.

Хүснэгт 1.3 Төсвийн нийт зарлагын хэмжээ, түүний өсөлт (тэрбум төгрөг)

Үзүүлэлт	2024 Гүйц	2025 Тод	Зөрүү
Төсвийн нийт зарлага	30,591.1	31,573.9	982.7
<i>ДНБ-д эзлэх хувь</i>	<i>38.2%</i>	<i>35.1%</i>	

Эх сурвалж: Сангийн яам, ЭЗХЯ-ны төсөөлөл

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 13.1.1 болон 13.1.2-д 05 дугаар сарын 31-ний өдрийн дотор батлагдсан төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг бүрэн дуусгаагүй, улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний санхүүжилтийг төсвийн хэмнэлтэд тооцохоор тусгасан байдаг. Тус зохицуулалтын хүрээнд “Төсвийн хэмнэлтэд тооцох тухай” тогтоолыг Засгийн газрын 2025 он 06 дугаар сарын 20-ны өдрийн хуралдаанаар хэлэлцэн баталсан бөгөөд хөрөнгө оруулалтын зардлын 535.9 тэрбум төгрөгийг төсвийн хэмнэлтэд тооцсон байна.

Ингэснээр нэгдсэн төсвийн хөрөнгө оруулалтын зардалд 2025 онд нийт 7,881.6 тэрбум төгрөг зарцуулахаар тусгагдсан ба нийгэм, эдийн засгийн үр ашигтай, тэргүүлэх ач холбогдол бүхий хөгжлийн томоохон төслүүдийг эрчимжүүлэх зарчим баримталсан.

Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.9-д “нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцлийн алдагдлын тухайн жилийн оны үнээр тооцсон дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь хэмжээг 2025 оноос эхлэн тухайн төсвийн жилийн дотоодын нийт бүтээгдэхүүний хоёр хувиас илүүгүй алдагдалтай, эсхүл ашигтай байна” гэж заасны дагуу тэнцвэржүүлсэн тэнцлийн ДНБ-д эзлэх хувь 2025 онд 1.5 хувийн алдагдалтай байхаар батлагдсан.

Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл 2025 онд ДНБ-ий 1.5 хувьтай тэнцэх хэмжээний алдагдалтай гарах тооцоололтой байгаа нь Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 19.9-д заасан зорилтот түвшний үзүүлэлтийг хангаж байна.

Хүснэгт 1.4 Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл, түүний гүйцэтгэл (ДНБ-д эзлэх хувь)

Үзүүлэлт	2024 Гүйц	2025 Тод
Хуулийн хязгаар	-2.0	-2.0
Тэнцвэржүүлсэн тэнцэл	-1.1	-1.5

Эх сурвалж: Сангийн яам, ЭЗХЯ-ны төсөөлөл

1.2.5. Гадаад худалдааны тэнцэл

Нийт экспорт 2025 онд 15.3 тэрбум ам.долларт хүрэхээр төсөөлж байна. Уул уурхайн гаралтай бүтээгдэхүүний экспорт 14.0 тэрбум ам.долларт, уул уурхайн бус бүтээгдэхүүний экспорт 1.3 тэрбум ам.доллар, тэр дундаа хөдөө аж ахуйн гаралтай бүтээгдэхүүний экспорт 717 сая ам.долларт тус тус хүрэхээр байна. Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн 250 км хатуу хучилттай авто зам ашиглалтад орсноор хилийн Гашуунсухайт боомтын нүүрс тээврийн эргэлт сайжрах, Тавантолгой-Ханги чиглэлийн төмөр замын тээвэр зохион байгуулалтыг сайжруулснаар хилийн Ханги боомтын нүүрс тээвэр нэмэгдэж, нүүрсний экспорт 2025 онд 85 сая тоннд хүрэхээр байна. Түүнчлэн, Оюу толгойн гүний уурхайн зэсийн баяжмал дахь цэвэр зэс, алтны агуулга нэмэгдэж зэсийн баяжмалын экспорт 2,024 мянган тонн, олборлолт

нэмэгдсэнтэй холбоотойгоор төмрийн хүдрийн экспорт 8,110 мянган тоннд хүрэхээр төсөөлж байна.

Харин нийт импорт 2025 онд 12.2 тэрбум ам.долларт хүрэхээр тооцоолж байна. Эдийн засгийн өсөлт хадгалагдаж, хэрэглээний бүтээгдэхүүн болон үйлдвэрлэлийн завсрын хэрэглээнд ашиглагдах бүтээгдэхүүний импорт нэмэгдэх төлөвтэй байгаа бол томоохон төслүүдийн бүтээн байгуулалтын нөлөөгөөр барилгын материалын импорт өсөхөөр байна.

1.2.6. Төлбөрийн тэнцэл

Засгийн газраас экспортын орлого, санхүүгийн дансны орох урсгалыг нэмэгдүүлж, төлбөрийн тэнцлийг сайжруулах, гадаад валютын улсын нөөцийг өсгөхөд чиглэсэн арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлж байна.

2. Хоёрдугаар бүлэг. Макро эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүдийн дунд хугацааны төсөөлөл

Энэ бүлгийг Монгол Улсын эдийн засгийн 2026-2028 оны төсөөлөл, нэгдсэн төсвийн үндсэн үзүүлэлтүүдийн 2026-2028 оны төсөөлөл дэд бүлгийн хүрээнд боловсрууллаа.

2.1. Монгол Улсын эдийн засгийн 2026-2028 оны төсөөлөл

Монгол Улсын эдийн засгийн дунд хугацааны төсөөллийг гадаад хүчин зүйлс болох дэлхийн эдийн засгийн төлөв, уул уурхайн бүтээгдэхүүний зах зээлийн хандлага, макро эдийн засгийн үзүүлэлтүүд болох дотоодын нийт бүтээгдэхүүн, хэрэглээний үнийн түвшин, мөнгөний бодлогын үндсэн үзүүлэлт, ажил эрхлэлт, ажилгүйдэл, гадаад худалдааны тэнцэл, төлбөрийн тэнцэл гэсэн агуулгаар бэлтгэв.

2.1.1. Дэлхийн эдийн засгийн төлөв

Сүүлийн жилүүдэд дэлхийн улс орнуудад бодлогын болон бүтцийн өөрчлөлтүүд явагдаж, худалдаа, хөрөнгө оруулалтын урсгал эрчимтэй өөрчлөгдөж буй энэ цаг үед дэлхийн улс төр, эдийн засгийн өрнөлд тодорхой бус байдал эрчимтэй нэмэгдэж байна. Тухайлбал, Дэлхийн тодорхой бус байдлын индексийн үзүүлэлт сүүлийн сард түүхэн дээд түвшинд хүрээд байна. ОУВС дэлхийн эдийн засгийн өсөлт 2025 онд 3.0 хувь, 2026 онд 3.1 хувь буюу цар тахлын өмнөх 3.7 хувийн дундаж өсөлтөөс бага байхаар төсөөлж байна. Худалдааны дайны цар хүрээ улам бүр тэлж болзошгүй байгаа нь дэлхийн эдийн засгийн идэвхжилийг хязгаарлах, инфляцыг өдөөх эрсдэлийг нэмэгдүүлж байна. Түүнчлэн, БНХАУ-ын үл хөдлөх салбарын уналт, ОХУ-Украины дайн болон Ойрх Дорнодын тогтворгүй байдал зэрэг эдийн засаг, геополитикийн тогтворгүй байдал зэрэг эрсдэлүүд дэлхийн эдийн засгийн төлөвийг муутгаж болзошгүй байна.

Хүснэгт 2.1 Дэлхийн эдийн засгийн өсөлтийн төсөөлөл

	2024	2025*	2026*
ОУВС (%)	3.3	2.8	3.0
Дэлхийн банк (%)	2.8	2.3	2.4
OECD (%)	3.3	2.9	2.9

Эх сурвалж: Дэлхийн эдийн засгийн төлөвийн тайлангууд, 2025 оны 6-7 дугаар сар

Зураг 2.1 Дэлхийн тодорхой бус байдлын индекс



Эх сурвалж: World Uncertainty Index

БНХАУ: БНХАУ-ын эдийн засгийн өсөлт 2025 оны эхний хагаст 5.3 хувьд хүрч, тус улсын засгийн газрын зорилтод 5 хувийн түвшнээс өндөр гарсан хэдий ч үл хөдлөх хөрөнгийн салбар уналттай, дотоод эрэлт сул хэвээр байгаа нь эдийн засгийн идэвхжилийг хязгаарлаж байна. Тус улсын засгийн газраас эдийн засгийн идэвхжилийг нэмэгдүүлэх хүрээнд хэрэглээг дэмжихэд чиглэсэн татаас, урамшуулал, татварын дэмжлэгийг хэрэгжүүлэхийн зэрэгцээ 2025 онд төсвийн алдагдлыг ДНБ-ий 3 хувиас 4 хувьд, засгийн газрын урт хугацаат бондын хэмжээг

1.3 их наяд юань, орон нутгийн бондын хэмжээг 4.4 их наяд юаньд хүргэж тус тус нэмэгдүүлэхээ зарлаад байна. БНХАУ-ын эдийн засгийн өсөлтийг ОУВС 2025 онд 4.8 хувь 2026 онд 4.2 хувь байх төсөөллийг энэ оны 7 дугаар сард зарлаад байна. Гэсэн хэдий ч худалдааны дайнтай холбоотой тодорхой бус байдал өндөр хэвээр байгаа нь БНХАУ-ын эдийн засгийн төлөвт сөргөөр нөлөөлж байна.

ОХУ: Дайнтай холбоотой цэрэг армийн зардлын өсөлтөөс шалтгаалсан төсвийн тэлэлтийн голлох нөлөөгөөр ОХУ-ын эдийн засаг 2024 онд 4.1 хувиар өссөн бол эдийн засгийн өсөлт 2025 оны 2 дугаар улиралд 1.1 хувьд хүрч саараад байна. Цаашид дайнтай холбоотойгоор тус улсын эдийн засагт тогтворгүй байдал үргэлжлэх төлөвтэй байна. ОХУ-ын эдийн засгийн өсөлт 2025 онд 0.9 хувь, 2026 онд 1.0 хувь орчимд байна гэж ОУВС тооцоолж байна.

АНУ: Хэрэглээ, хөрөнгө оруулалтын өсөлтийн нөлөөгөөр АНУ-ын эдийн засаг 2024 онд 2.8 хувиар тэлсэн бол импортын өсөлт саарсан нөлөөгөөр тус улсын эдийн засгийн өсөлт 2025 оны 2 дугаар улиралд 3.0 хувьд хүрч эрчимжлээ. ОУВС тус улсын эдийн засгийн 2025 оны өсөлтийн төсөөллийг 1.9 хувь, 2026 оны өсөлтийн төсөөллийг 2.0 хувь болгож, өмнөх төсөөллөөс тус тус 0.1 нэгж хувь болон 0.3 нэгж хувиар нэмэгдүүлээд байна. Тус улсын өрнүүлж буй худалдааны дайны цар хүрээ улам бүр нэмэгдэж байгаа нь АНУ төдийгүй дэлхийн худалдаа, хөрөнгө оруулалтын урсгал хумигдах, инфляц өсөх эрсдэлийг нэмэгдүүлж байна.

Евро бүс: Евро бүсийн эдийн засаг 2025 оны 2 дугаар улиралд өмнөх оны мөн үеэс 1.4 хувиар өслөө. Бүсийн эдийн засгийн 30 орчим хувийг бүрдүүлдэг ХБНГУ-ын эдийн засгийн идэвхжил сул хэвээр байгаа бөгөөд бүсийн эдийн засгийн өсөлт 2025 онд 1.0 хувьд хадгалагдах бол 2026 онд бодит цалингийн өсөлт, ХБНГУ-ын төсвийн тэлэлтийн нөлөөгөөр өсөлт 1.2 хувьд хүрч эрчимжинэ гэж ОУВС тооцоолж байна.

2.1.2. Уул уурхайн бүтээгдэхүүний зах зээлийн хандлага


Зэсийн үнэ: Лондоны металлын бирж дэх цэвэр зэсийн дундаж үнэ 2024 онд 9,145 ам.доллар болж, өмнөх оноос 7.9 хувиар өссөн байна. Харин 2025 оны эхний 7 сарын байдлаар 9,475 ам.доллар болж, өмнөх оноос 3.6 хувиар өссөн байна. АНУ-ын тарифын бодлогын шийдвэрүүдээс үүдэлтэй томоохон үйлдвэрүүдийн зэсийн нөөцийн хэлбэлзэл дэлхийн зах зээл дээрх зэсийн үнэд нөлөөлж байна. Дэлхийн эдийн засагт тодорхой бус байдал нэмэгдэж байгаа хэдий ч цахилгаан автомашин, сэргээгдэх эрчим хүч, тоон өгөгдөл боловсруулах төвүүд, технологийн салбарын хурдацтай хөгжлөөс шалтгаалан зэсийн эрэлт нэмэгдэж үнэ өсөхөөр байна. Олон улсын шинжээчдийн таамаглалаар зэсийн дундаж үнэ 2025 онд 9,200 ам.доллар, 2026 онд 9,700 ам.долларт хүрэхээр байна.

Алтны үнэ: Лондоны металлын бирж дэх алтны дундаж үнэ 2024 онд 2,389 ам.доллар болж, өмнөх оноос 22.9 хувиар өссөн байна. Харин 2025 оны эхний 7 сарын байдлаар 3,115 ам.доллар болж, өмнөх оноос 30.4 хувиар өссөн байна. АНУ-ын Холбооны нөөцийн банк бодлогын хүүгээ 2024 онд бууруулсан нь алтны эрэлтийг нэмэгдүүлж, үнэ өсөхөд нөлөөллөө. Дэлхийн тодорхой бус байдал нэмэгдэж байгаатай холбоотойгоор алтны үнэ үргэлжлэн өсөх төлөвтэй байна. Олон улсын шинжээчдийн таамаглалаар алтны дундаж үнэ 2025 онд 2,900 ам.доллар, 2026 онд 2,800 ам.долларт хүрэхээр байна.

Зураг 2.2 Зэсийн үнийн хөдөлгөөн, төсөөлөл (ам.доллар/тонн)




Зураг 2.3 Алтны үнийн хөдөлгөөн, төсөөлөл (ам.доллар/унц)



Эх сурвалж: Блүүмберг терминал

Коксжих нүүрсний үнэ: Сингапурын бирж дэх Австралийн сайн чанарын коксжих нүүрсний дундаж үнэ 2024 онд 243 ам.доллар болж, өмнөх оноос 17.9 хувиар буурсан байна. Харин 2025 оны эхний 7 сарын байдлаар 184 ам.доллар болж, өмнөх оноос 24.2 хувиар буурлаа. Дэлхийн коксжих нүүрсний хэрэглээний хоёрдогч том хэрэглэгч болох Энэтхэг улс руу чиглэсэн гангийн нийлүүлэлт нэмэгдсэн, БНХАУ-ын ган хайлуулах томоохон үйлдвэрүүд коксжих нүүрсний татан авалтаа удаашруулсан зэрэг нь коксжих нүүрсний үнэ буурахад голлон нөлөөллөө. Дэлхийн тодорхой бус байдал, худалдааны дайнаас шалтгаалан нүүрсний үнэ буурах дарамт нэмэгдэж байна. Олон улсын шинжээчдийн таамаглалаар коксжих нүүрсний дундаж үнэ 2025-2026 онд 175 ам.долларт хүрч буурахаар байна. Монгол Улсын нүүрсний экспортын дундаж үнэ 2025-2026 онд 70 ам.доллар байхаар тооцоолж байна.

Зураг 2.4 Нүүрсний үнийн хөдөлгөөн, төсөөлөл (ам.доллар/тонн)



Зураг 2.5 Төмрийн хүдрийн үнийн хөдөлгөөн, төсөөлөл (ам.доллар/унц)



Эх сурвалж: Блүүмберг терминал

Төмрийн хүдрийн үнэ: Төмрийн хүдрийн (62 хувийн агууламжтай) үнэ 2024 онд 110 ам.доллар болж, өмнөх оноос 8.0 хувиар буурсан байна. Харин 2025 оны эхний 7 сарын байдлаар 100 ам.доллар болж, өмнөх оноос 9.3 хувиар буурлаа. Австрали, Бразил зэрэг улсуудын нийлүүлэлтийн өсөлт, БНХАУ-ын үл хөдлөх хөрөнгийн салбарын уналт төмрийн хүдрийн үнэ буурахад голлон нөлөөллөө. БНХАУ-ын үл хөдлөх хөрөнгийн салбар богино хугацаанд сэргэх төлөвгүй байгаагаас гадна Австрали, Бразил зэрэг улсуудын олборлолт тогтвортой өсөхөөр байгаа тул төмрийн хүдрийн үнэ буурах төлөвтэй байна. Олон улсын шинжээчдийн таамаглалаар төмрийн хүдрийн дундаж үнэ 2025 онд 95 ам.доллар, 2026 онд 90 ам.долларт хүрэхээр байна. Монгол Улсын төмрийн хүдрийн экспортын дундаж үнэ 2025 онд 72 ам.доллар, 2026 онд 69 ам.доллар байхаар тооцоолж байна.

Газрын тосны үнэ: Брент төрлийн газрын тосны дундаж үнэ 2024 онд 80 ам.доллар болж, өмнөх оны эцсээс 2.8 хувиар буурсан байна. Харин 2025 оны эхний 7 сарын байдлаар 68 ам.доллар болж, өмнөх оны эцсээс 9.3 хувиар буурлаа. АНУ болон Канад, Бразил зэрэг улсуудын газрын тосны олборлолт нэмэгдсэнээс гадна БНХАУ-ын эрэлт бага байсан нь газрын тосны үнэ буурахад голлон нөлөөллөө. Геополитикийн тодорхой бус байдал, худалдааны дайнаас үүдэлтэй дэлхийн эдийн засгийн идэвхжилийн удаашралаас шалтгаалан газрын тосны үнэ буурах төлөвтэй байна. Олон улсын шинжээчдийн таамаглалаар Брент төрлийн газрын тосны дундаж үнэ 2025 онд 75 ам.доллар, 2026 онд 70 ам.долларт хүрэхээр байна. Монгол Улсын газрын тосны экспортын дундаж үнэ 2025 онд 75 ам.доллар, 2026 онд 72 ам.доллар байхаар тооцоолж байна.

Зураг 2.6 Газрын тосны үнийн хөдөлгөөн, төсөөлөл (ам.доллар/баррель)



Эх сурвалж: Блуумберг терминал

2.1.3. Дотоодын нийт бүтээгдэхүүн

Нэрлэсэн дотоодын нийт бүтээгдэхүүн 2026 онд 102.4 их наяд төгрөгт хүрч, эдийн засгийн өсөлт 5.7 хувь байхаар хүлээгдэж байна. Эдийн засгийн өсөлт 2027 онд 6.3 хувь, 2028 онд 6.5 хувь орчимд байна. Дунд хугацаанд уул уурхайн салбарт зэсийн баяжмал үйлдвэрлэл, нүүрс, төмрийн хүдэр болон алтны олборлолт нэмэгдэхээр байна. Тухайлбал, Оюу толгойн гүний уурхайн олборлолт үргэлжилж, зэсийн баяжмал үйлдвэрлэл өсөхийн зэрэгцээ цэвэр зэсийн агуулга нэмэгдэх нь уул уурхайн салбарын эдийн засагт оруулах хувь нэмрийг нэмэгдүүлнэ. Түүнчлэн, боомтуудын хил дамнасан төмөр замын холболттой холбоотойгоор нүүрс олборлолт нэмэгдэх бол Монгол-Францын хамтарсан ураны төсөл 2028 оноос олборлолт эхлүүлэхээр байгаа нь салбарын үйлдвэрлэлийг нэмэгдүүлэхээр байна.

Тээврийн салбарт боомтуудын хил холболтын бүтээн байгуулалт хийгдэж, тээврийн дэд бүтэц сайжирснаар уул уурхайн болон уул уурхайн бус бүтээгдэхүүний ачаа тээвэр нэмэгдэж, салбарын дунд хугацаанд өсөлтийг хангана. Хөдөө аж ахуй, боловсруулах салбарын өсөлт “Хүнсний хувьсгал” хөдөлгөөн, “Цагаан алт” хөтөлбөр, “Атар-4” аяны нөлөөгөөр дунд хугацаанд тогтвортой хадгалагдах төлөвтэй байна. Түүнчлэн, ирэх онуудад хэрэгжих томоохон төслүүд барилга, эрчим хүч, боловсруулах салбарын өсөлтийг тэтгэх хүлээлттэй байна.

2.1.4. Хэрэглээний үнийн түвшин, мөнгөний бодлогын үндсэн үзүүлэлт

Инфляц 2026 онд дунджаар 7.0 хувь буюу төв банкны зорилтот интервалд хадгалагдах төлөвтэй байна. Тодруулбал, ирэх онд цахилгааны тариф болон нийтийн тээврийн үйлчилгээний үнийн өсөлтийн суурь үеийн нөлөө арилж, эрэлтийн шинжтэй инфляцын дарамт буурснаар инфляц төв банкны зорилтот интервалд хүрч тогтворжихоор байна.

Дунд хугацаанд инфляц үргэлжлэн буурч 2027, 2028 онд харгалзан 6.0, 5.0 хувьд хүрэхээр төсөөлж байна. Тодруулбал, “Хүнсний хувьсгал” хөдөлгөөн, “Атар-4

тариалангийн тогтвортой хөгжлийн аян” зэрэг эрчимжсэн мал аж ахуйг хөгжүүлэх, дотоодын хүнсний үйлдвэрлэл болон нийлүүлэлтийг нэмэгдүүлэхэд чиглэсэн арга хэмжээнүүдийн үр дүнд дунд хугацаанд хүнсний үнийн өсөлт буурах хүлээлттэй байна. Мөн төрөөс мөнгөний бодлогын талаар 2025 онд баримтлах үндсэн чиглэлд зааснаар төв банк 2027 оноос инфляцын зорилтыг 5 хувь болгон бууруулах мөнгөний бодлогыг хэрэгжүүлэхээр байна.

2.1.5. Ажил эрхлэлт, ажилгүйдлийн түвшин

Төрөлтийн түвшин 1990-2005 оны хооронд буурснаас шалтгаалан хөдөлмөрийн насны хүн амын өсөлт удааширч, ажиллах хүчний нийлүүлэлт саарч буй байдал 2026 оноос эхлэн суларч, хөдөлмөрийн насны хүн амын өсөлт сэргэж эхлэх хүлээлтэй байна.

Цаашид 2026-2028 онд жилд дунджаар 34 мянган хүн тэтгэвэрт гарах төлөвтэй байгаа бол хөдөлмөрийн зах зээлд жилд дунджаар 58 мянган шинэ төгсөгч нийлүүлэгдэхээр байна. Иймд жил бүр шинээр төгссөн 24 мянган хүнийг ажлын байраар хангах шаардлага үүсэж байна. Судалгаагаар¹ цар тахлаас өмнөх 4 жилийн хугацаанд жилд дунджаар 75 мянган ажлын байр, үүний дотор 45 мянган шинэ ажлын байр бий болох хүлээлттэй байсан бол цар тахлаас хойших онуудад жилд дунджаар 85 мянган ажлын байр, үүнээс 52 мянган шинэ ажлын байр бий болох хүлээлттэй болж нэмэгдсэн байна.

Эдгээрийн үр дүнд ажилчдын тоо 2026 онд 1 сая 422 мянгад хүрч, цаашид өсөлтөө тогтвортой хадгалан 2027-2028 онд ойролцоогоор 1 сая 480 мянгад хүрэх төлөвтэй байна. Үүний зэрэгцээ иргэдийн хөдөлмөр эрхлэх боломж, сонирхол нэмэгдсэнээр ажиллах хүчнээс гадуурх хүн ам буурна гэж таамаглаж байна. Ингэснээр ажиллах хүчний оролцооны түвшнийг 2026 онд 62.4 хувь, цаашлаад 2028 онд 63.8 хувьд хүргэх бөгөөд 2026-2028 онд ажилгүйдлийн түвшин 5.6 хувь орчимд хэлбэлзэх хандлагатай байна.

2.1.6. Гадаад худалдааны тэнцэл

Монгол Улсын гадаад худалдааны тэнцэл 2026-2028 онд дунджаар 2.9 орчим тэрбум ам.долларын ашигтай байх төлөвтэй байна. Нийт экспорт 2026 онд 16.6 тэрбум ам.доллар, 2027 онд 17.6 тэрбум ам.доллар, 2028 онд 18.5 тэрбум ам.долларт хүрэхээр төсөөлж байна. Уул уурхайн салбарт Оюу Толгойн зэсийн баяжмал дахь цэвэр зэсийн агуулга, алтны олборлолт нэмэгдэж, экспортын орлогыг нэмэгдүүлэхээр байна. Түүнчлэн, төмөр замын суурь дэд бүтцийг сайжруулж, хил холболтын бүтээн байгуулалтын ажлуудыг бүрэн хэрэгжүүлж дууссанаар нүүрсний экспорт нэмэгдэхээр байна. Хөдөө аж ахуй болон боловсруулах салбарын үйлдвэрлэлийн өсөлтийн нөлөөгөөр ноолуур, арьс шир, малын мах зэрэг уул уурхайн бус бүтээгдэхүүний экспорт дунд хугацаанд өсөхөөр байна.

Нийт импорт дунд хугацаанд буюу 2028 онд 15.9 тэрбум ам.долларт хүрэхээр байна. Дунд хугацаанд эдийн засгийн идэвхжил хадгалагдаж, том төслүүдийн бүтээн байгуулалтын нөлөөгөөр импортын өсөлт дунджаар 8 орчим хувьд хадгалагдахаар

¹ Хөдөлмөрийн зах зээлийн эрэлтийн барометрийн судалгаа

байна. Мөн бараа, бүтээгдэхүүнийг импортлохтой холбоотой бүртгэлийг автоматжуулж, боомтуудын хүчин чадлыг өргөжүүлж, нэг боомт дээр төвлөрсөн ачааллыг бууруулснаар импортын барааны эргэлтийн хурд нэмэгдэхээр хүлээгдэж байна.

2.1.7. Төлбөрийн тэнцэл

Дунд хугацаанд макро эдийн засгийн тогтвортой байдлыг хангах, хөрөнгө оруулалтын орчныг сайжруулах замаар гадаад зах зээлээс татах хөрөнгийн урсгалыг нэмэгдүүлэх шаардлагатай байна. Энэ хүрээнд Засгийн газрын зүгээс хөрөнгө оруулалтын орчныг сайжруулж, зээлжих зэрэглэлийг үргэлжлүүлэн ахиулах замаар хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлж, гадаад зах зээлээс хөрөнгө татах өртөг, зардлыг бууруулах бодлогыг баримталж байна.

2.2. Нэгдсэн төсвийн үндсэн үзүүлэлтүүдийн 2026-2028 оны төсөөлөл

Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 12.3.8-д заасны дагуу төсвийн тэнцвэржүүлсэн орлогын төлөвлөгөө болон түүний гүйцэтгэл, төсвийн нийт зарлагын хэмжээ, түүний өсөлт, төсвийн тэнцвэржүүлсэн тэнцлийн зорилтот үзүүлэлт, түүний гүйцэтгэлийн талаарх нэгдсэн төсвийн үндсэн үзүүлэлтүүдийн төсөөллийг боловсрууллаа.

2.2.1. Төсвийн тэнцвэржүүлсэн орлогын төсөөлөл

Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан төсвийн тусгай шаардлагын² дагуу нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлого 2026 онд 31,930.0 тэрбум төгрөгт хүрэхээр тооцлоо.

Хүснэгт 2.2 Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлогын төсөөлөл (тэрбум төгрөг)

Үзүүлэлт	2026 төсөөлөл	2027 төсөөлөл	2028 төсөөлөл
Тэнцвэржүүлсэн орлогын хэмжээ	31,930.0	33,761.0	37,299.3
ДНБ-д эзлэх хувь	31.2	29.3	28.2

Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар: Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын орлогыг ОУВС-гийн бодит үйлчилж буй хувь хэмжээ (effective tax rate)-ний аргачлал болон бусад эконометрик тооцооллууд, макро эдийн засгийн үндсэн үзүүлэлт, уул уурхайн бүтээгдэхүүний үнэ, биет хэмжээний төсөөлөлд үндэслэн тооцлоо. Ирэх онуудад экспортын биет хэмжээ нэмэгдэхээс гадна нүүрсний баяжуулах үйлдвэрийн нөлөөгөөр нийт нүүрсэнд эзлэх баяжуулсан коксжих нүүрсний хувь хэмжээ өсөхийн зэрэгцээ Оюу Толгойн экспортын зэсийн баяжмал дахь цэвэр зэсийн агуулга нэмэгдэхээр байгаа нь аж ахуйн нэгжийн орлогын албан татварын орлого өсөхөд эерэг нөлөө үзүүлэх хэдий ч дэлхийн тодорхой бус байдал, худалдааны дайнаас шалтгаалан нүүрсний үнэ буурах дарамт нэмэгдэж, татварын орлогод сөргөөр нөлөөлж болзошгүй байна.

Хувь хүний орлогын албан татвар: Ирэх онуудад ажиллах хүчний оролцооны түвшин нэмэгдэж, нэрлэсэн дундаж цалин ойролцоогоор 10 орчим хувиар өсөх төсөөлөлтэй байна. Улмаар, хувь хүний орлогын албан татварын орлого 2026-2028 онд дунджаар 3.0 хувиар өсөхөөр тооцлоо.

Нэмэгдсэн өртгийн албан татвар: Тус татвар нь эдийн засгийн дотоод идэвхжил, иргэдийн худалдан авах чадварын ерөнхий байдлыг илэрхийлэх чухал үзүүлэлт болдог. 2026-2028 онд НӨАТ-ын орлого эдийн засгийн дотоод эрэлтийн ерөнхий хандлагыг дагах суурь таамаглалыг дэвшүүлсэн. НӨАТ-ын нийт орлогын 60 орчим хувийг импортын албан татвар бүрдүүлдэг бөгөөд иргэдийн хэрэглээний өсөлт, хөрөнгө оруулалтын тоног төхөөрөмжийн импорт нэмэгдэх нь тус орлогод чухал нөлөө үзүүлдэг. Ирэх онуудад Засгийн газраас хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээ болон хувийн секторын хөрөнгө оруулалтын нөлөөгөөр хөрөнгө оруулалтын

² 6 дугаар зүйл. Төсвийн тусгай шаардлага: 6.1.1. Нэгдсэн төсвийн орлогыг тэнцвэржүүлсэн журмаар тооцдог байх;

бүтээгдэхүүний импорт өсөх хүлээлттэй байгаа нь НӨАТ-ын орлогод эергээр нөлөөлөх төсөөлөлттэй байна.

Онцгой албан татварын орлого: Ирэх онд боловсруулах салбар нэрлэсэн дүнгээр ойролцоогоор 11.0 хувиар, ундаа, усны үйлдвэрлэл 8.5 орчим хувиар өсөх, түүнчлэн суудлын автомашины импорт нэмэгдэх нөлөөгөөр онцгой албан татварын орлого 2026-2028 онд дунджаар 6.0 хувиар өсөх төсөөлөлттэй байна.

Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр: Зэсийн баяжмал дахь цэвэр зэсийн агууламж нэмэгдэхтэй холбоотойгоор зэсийн баяжмалын экспортын орлогоос төсөвт төвлөрөх орлого нэмэгдэх хүлээлттэй байгаа бол нүүрсний дэлхийн зах зээлийн үнэ буурах хандлагатай байгаа нь тус орлогын өсөлтийг сааруулах тооцоололтой байна. Үндэсний баялгийн сангийн тухай хуулийн 11.1.1.а заалтад ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрөөс Төсвийн тогтворжуулалтын сан болон Орон нутгийн хөгжлийн нэгдсэн санд хуваарилаад үлдэх хэсгийн 65 хувийг Ирээдүйн өв санд төвлөрүүлнэ гэж заасан.

Ирээдүйн өв сангийн тухай хууль 2016 оны 2 дугаар сарын 5-ны өдөр батлагдан, 2017 оноос эхлэн хүчин төгөлдөр мөрдөгдөж эхэлсэн. Улмаар ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрөөс Тогтворжуулалтын сан, Ирээдүйн өв сан, улсын төсөвт хуваарилах болсон. Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрөөс Ирээдүйн өв санд хуваарилсан сүүлийн 3 жилийн хувь хэмжээг харвал, 2023 онд хуваарилалт хийгдээгүй, 2024 онд 20 хувиар хуваарилсан бол 2025 оны төсвийн тухай хуульд 40 хувиар хуваарилалт хийхээр батлагдсан байна. 2025 оны эхний 7 сарын байдлаар ирээдүйн өв санд 592.4 тэрбум төгрөг төвлөрсөн бөгөөд 2025 оны эцэст 1.3 их наяд төгрөг хуримтлагдахаар төсөөлж байна. Дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдлийн хуулийн төсөлд Ирээдүйн өв сангийн орлогыг хуульд заасан 65 хувиар төвлөрүүлэхээр тооцлоо.

2.2.2. Төсвийн нийт зарлагын хэмжээ, түүний өсөлт

Нэгдсэн төсвийн нийт зарлага 2026 онд 32,980.0 тэрбум төгрөг болж, дотоодын нийт бүтээгдэхүүний 32.2 хувьд хүрэхээр тооцлоо.

Хүснэгт 2.3 Нэгдсэн төсвийн нийт зарлагын төсөөлөл (тэрбум төгрөг)

Үзүүлэлт	2026 төсөөлөл	2027 төсөөлөл	2028 төсөөлөл
Нийт зарлагын дээд хэмжээ	32,980.0	34,626.0	37,829.2
ДНБ-д эзлэх хувь	32.2	30.0	28.6

“Шинэ сэргэлтийн бодлого”-ын Хот, хөдөөгийн сэргэлтийн бодлогын хэрэгжилтийн хүрээнд иргэдийн бодит орлогыг хамгаалах, шинээр батлагдсан хууль, тогтоомжийн хэрэгжилтийг хангахад шаардлагатай төсвийг хуваарилах бодлого баримтлан эрүүл мэндийн тусламж үйлчилгээ, нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмж, хүүхдийн мөнгөн тэтгэмж, халамжийн тэтгэвэр, түүнчлэн төрийн албан хаагчийн цалин хөлс, зээлийн үйлчилгээний төлбөр зэрэг өсөн нэмэгдэх зардлуудыг үргэлжлүүлэн олгохоор тооцоолов.

Дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдлийн зардлын төсөөлөлд иргэдийн нийгмийн баталгааг сайжруулах хүрээнд нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийг инфляцын түвшинтэй уялдуулан нэмэгдүүлэх зардал, тэтгэвэр

авагчдын дундаж өсөлтийг тус тус тусган тооцоолсон болно. Төрийн албан хаагчдын чиг үүргийн давхардлыг арилгаж, орон тоог бууруулж, халамжийн үйлчилгээг зорилтот бүлгийн нийгмийн баталгааг дээшлүүлэхэд чиглүүлэх, мөн тэтгэвэр, тэтгэмжийн хэмжээг зохистой түвшинд олгох ба төрийн үр ашиггүй зардлуудыг бууруулах бодлого баримталсан.

2.2.3. Нэгдсэн төсвийн суурь зарлагын дээд хэмжээ

Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль 2024 оны 8 дугаар сарын 30-ны өдөр батлагдаж, Дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэлд “нэгдсэн төсвийн суурь зарлагын дээд хэмжээ”-ний үзүүлэлтийг тусгахаар заасан. Нийт зарлагаас үнэт цаас болон гадаад зээлээр санхүүжих зардлыг хасаж тооцсон нэгдсэн төсвийн суурь зарлагын хэмжээ 2026 онд 29,859.1 тэрбум төгрөгт хүрэхээр байна.

Хүснэгт 2.4 Нэгдсэн төсвийн суурь зарлагын төсөөлөл (тэрбум төгрөг)

Үзүүлэлт	2026 төсөөлөл	2027 төсөөлөл	2028 төсөөлөл
Суурь зарлагын дээд хэмжээ	29,859.1	31,452.6	33,254.6
ДНБ-д эзлэх хувь	29.2	27.3	25.1

2.2.4. Төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл

Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцлийг 2026-2028 онд дотоодын нийт бүтээгдэхүүний хоёр хувиас бага алдагдалтай байхаар тооцсон нь Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 19.9-д заасан тухайн төсвийн жилийн дотоодын нийт бүтээгдэхүүний хоёр хувиас илүүгүй алдагдалтай, эсхүл ашигтай байх хуулийн шаардлагыг хангаж байна.

Хүснэгт 2.5 Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл (тэрбум төгрөг)

Үзүүлэлт	2026 төсөөлөл	2027 төсөөлөл	2028 төсөөлөл
Тэнцвэржүүлсэн тэнцэл	-1,050.0	-865.0	-529.9
ДНБ-д эзлэх хувь	-1.0	-0.8	-0.4

3. Гуравдугаар бүлэг. Монгол Улсын 2026 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2027-2028 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар

Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.3.1 дэх заалтын дагуу дунд хугацааны төсвийн бодлогыг төсвийн тусгай шаардлагад нийцүүлэн тодорхойллоо.

3.1. Дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэл өөрчлөх үндэслэл

Дэлхийн эдийн засагт тодорхой бус нөхцөл байдал өндөр байгаа энэ цаг үед манай улсын экспортын гол бүтээгдэхүүн болох нүүрсний үнэ 2025 оны эхний 6 сард дунджаар 70 ам.доллар болж, өмнөх оны мөн үеэс 40 хувиар, нийт экспорт 2025 оны эхний 6 сард 6.6 тэрбум ам.доллар болж, өмнөх оны мөн үеэс 20 хувь буюу 1.3 тэрбум ам.доллараар, төсвийн нийт орлого 14.0 их наяд төгрөг болж, 6 хувь буюу 0.9 их наяд төгрөгөөр тус тус буураад байна. Цаашдын дэлхий дахины эдийн засаг дахь тодорхой бус байдал үргэлжлэх эрсдэл өндөр байгаагийн улмаас манай улсын эдийн засгийн нийт эрэлт саарах хандлага үргэлжлэх төлөвтэй байна.

Монгол Улсын төсвийн 2026 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2027-2028 оны төсвийн төсөөллийн тухай хуульд нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлогын доод хэмжээ болон нийт зарлагын дээд хэмжээг 33.4 их наяд төгрөг байхаар баталсан. Эдийн засгийн дээрх нөхцөл байдлын улмаас 2026 оны төсвийн хүрээний мэдэгдэл дэх төсвийн тэнцвэржүүлсэн орлого, нийт зарлагын дүн хангагдахгүй байх эрсдэл үүсээд байна.

Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд 2025 оны 7 дугаар сарын 09-ний өдөр “Дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэлд нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлогын доод хэмжээ болон нийт зарлагын дээд хэмжээг нэгэн зэрэг бууруулах өөрчлөлт орсонтой холбогдуулан жилийн төсөв, төсвийн тодотголын төслийг Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх, батлахад энэ хуулийн 7.5-д заасан хязгаарлалт хамаарахгүй” байхаар нэмэлтээр тусган баталсан.

Дээр дурдсан нөхцөл байдал болон хууль, эрх зүйн орчинтой уялдуулан Монгол Улсын нэгдсэн төсвийн 2026 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2027-2028 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулж, Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн дагуу дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдлийн үндсэн үзүүлэлтүүд болон үзүүлэлтийн хэмжээг өөрчлөх шаардлагатай байна.

3.2. Дунд хугацаанд баримтлах төсвийн бодлого

Монгол Улсын нэгдсэн төсвийн 2026 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2027-2028 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулахдаа макро эдийн засгийн тогтвортой байдлыг хангах, эдийн засаг дахь төрийн оролцоог үе шаттай бууруулж, хувийн хэвшлийн бизнес тэлэх орон зайг нэмэгдүүлэх, эдийн засгийн салбаруудын бүтээмжийг дэмжих бодлогуудыг баримтлахаар тооцлоо.

Нэг. Макро эдийн засгийг тогтворжуулахад мөчлөг сөрсөн төсвийн бодлого хэрэгжүүлнэ.

Дэлхий дахинд тодорхой бус байдал өндөр байгаагаас шалтгаалан олон улсын зах зээл дээрх ашигт малтмалын бүтээгдэхүүний үнэ хэлбэлзэл өндөртэй байгаа нь манай улсын эдийн засгийн гадаад эрэлтийг сааруулах төлөвтэй байна. Иймд эдийн засгийн нийт эрэлтийг дэмжиж, макро эдийн засгийн тогтвортой байдлыг хадгалахын тулд нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцлийг 2026 онд ДНБ-ий 1.3 хувьтай тэнцэх дүнгээр алдагдалтай баталж хэрэгжүүлэхээр ТХМ-ийг боловсрууллаа. Цаашид дэлхийн эдийн засаг дахь тодорхой бус байдал намжих таамаглалын хүрээнд 2027, 2028 онд төсвийн бодлогын орон зайг тогтвортой хадгалах болон нэмэгдүүлэх зорилгоор нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцлийн алдагдлын дүнг үе шаттай бууруулахаар хуулийн төсөлд тусгав.

Хоёр. Эдийн засаг дахь төрийн оролцоог бууруулж, хувийн хэвшлийн бизнес тэлэх орон зайг нэмэгдүүлнэ.

Төсвийн тэнцвэржүүлсэн орлого болон нэрлэсэн ДНБ-ий харьцаа 2018, 2019 онуудад 29 хувь байсан бол 2023 онд 33 хувь, 2024 онд 37 хувь болж нэмэгдээд байна. Цаашид уг харьцааг 2026 онд 30.9 хувь, 2027 онд 29.3 хувь, 2028 онд 28.2 хувь болгох үе шаттай бууруулахаар хуулийн төсөлд тусгалаа. Ингэснээр хувийн хэвшлийг дэмжсэн татварын шинэчлэл хийгдэх орон зайг болгож, хувийн хэвшлийн бизнесийн тэлэх боломжийг бүрдүүлэх, улмаар эдийн засаг дахь төрийн оролцоог үе шаттай бууруулна.

Мөн төсвийн нийт зардлын эдийн засаг дахь харьцааг 2026 онд 32.2 хувь, 2027 онд 30 хувь, 2028 онд 28.6 хувь байхаар үе шаттай бууруулахаар хуулийн төсөлд тусгав. Төсвийн зардлын өсөлтийг ийнхүү хязгаарлаж байгаа нь төсвийн зарцуулалтыг үр ашгийг нэмэгдүүлэх, эрэлтийн гаралтай инфляцыг хязгаарлахад мөнгөний бодлоготой уялдах замаар дунд хугацаанд инфляцын зорилтот дүнг үе шаттай бууруулахад хувь нэмэр оруулна. Ингэснээр, ингэснээр дунд хугацаанд зээлийн хүү буурах, Засгийн газрын зээлжих зэрэглэл тогтвортой нэмэгдэх, төсвийн бодлогын орон зай бэхжих зэрэг чухал ач холбогдолтой юм.

Төсвийн сахилга батыг сайжруулан, урсгал зардлын тэлэлтийг хязгаарлаж, төрөөс үзүүлж буй нийгмийн халамж, тусламж, үйлчилгээг зорилтот бүлэгт чиглүүлэх бодлогыг хэрэгжүүлнэ. Уг бодлогын хүрээнд нийгмийн халамжийн тухай хуульд заасны дагуу төсвөөс хуваарилах зардлын дээд хэмжээг 2026 онд ДНБ-ий 2.6 хувь, 2027 онд 2.4 хувь, 2028 онд 2.2 хувь болгож үе шаттай бууруулахаар тусгав.

Гурав. Салбаруудын үйл ажиллагааг зах зээлийн механизм руу чиглүүлж, бүтээмжийг нэмэгдүүлэх, эдийн засгийн төрөлжилтийг дэмжинэ.

Хуулийн төсөлд эдийн засгийн өсөлтийг 2026 онд 5.7 хувь, 2027, 2028 онд 6 хувиас дээш түвшинд хадгалахаар тооцож тусгав. Мөн инфляцыг төв банкны зорилтот интервалд байхаар тооцож, хуулийн төсөлд тусгасан болно. Эдийн засгийн өсөлтийг тогтвортой хадгалж, инфляцыг бууруулахад салбар бүр дэх хөрөнгө оруулалт хийх, үйлдвэрлэл эрхлэх, худалдаа худалдаа хийх зэрэг бизнесийн орчныг сайжруулж, хувийн хэвшлийн бизнес эрхлэх эрх чөлөөг хангана. Ингэхдээ, хөрөнгө оруулалтын хууль, эрх зүйн орчны шинэчлэлтийг хийж, хөрөнгө оруулагчдыг дэмжих

багц хуулийн төслийг боловсруулан, хөрөнгө оруулалтыг хязгаарласан, хаасан зэрэг ялгамжтай байдлыг арилгана. Мөн төр, хувийн хэвшилтэй өрсөлдөхгүй байх зарчмыг баримталж, Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хууль дахь зохицуулалтуудыг хялбаршуулж, бүх аймагт түншлэлээр төсөл хэрэгжүүлэх боломжийг нээж, төр шаардлагатай зарим хөрөнгө оруулалтыг хувийн хэвшилтэй хамтран хэрэгжүүлэх эрх зүйн орчныг бүрдүүлнэ. Эдгээр бодлогуудыг зарим салбаруудад хэрэгжүүлэх арга замуудаас энд тодруулав.

Боловсруулах салбар: Бүтээгдэхүүний боловсруулалтын түвшнийг шат ахиулж, нэмүү өртөг шингэсэн уул уурхайн бүтээгдэхүүний экспортыг нэмэгдүүлэх, зэсийн баяжмал боловсруулах үйлдвэр, нүүрс баяжуулах үйлдвэр, гангийн үйлдвэр, ураны олборлолт, хүдрийн баяжмал боловсруулах үйлдвэр, газрын тос боловсруулах үйлдвэр байгуулахад хөрөнгө оруулалт татах ажлыг үргэлжлүүлэн, үйлдвэрлэл технологийн паркуудын бүтээн байгуулалтын ажлыг эрчимжүүлнэ. Түүнчлэн төрөөс хүнс, хөдөө аж ахуйн салбарт хэрэгжүүлж буй Атар-4, Хүнсний хувьсгал, Шинэ хоршоо, Цагаан алт хөдөлгөөний хэрэгжилтэд хяналт хийж, үр ашгийг нэмэгдүүлэхэд анхаарна.

Уул уурхай: Уул уурхайн экспортыг нэмэгдүүлэхэд уул уурхайн бүтээгдэхүүний биржийн арилжааг идэвхжүүлэн тогтмолжуулж, тогтолцоог өргөжүүлнэ. Уул уурхайн салбарт хөрөнгө оруулалтыг татах хүрээнд геологи, хайгуулын ажлыг эрчимжүүлж, хайгуулын лицензийн тоог нэмэгдүүлэх, хайгуулын ажлын гүйцэтгэлийг сайжруулж, ордуудын ашиглалтыг нэмэгдүүлэх ажлыг өргөжүүлнэ. Ашигт малтмалын салбарын нөөцийн үнэлгээг сайжруулж, мэдээллийн ил тод байдлыг хангах олон улсын стандартад нийцсэн сан бүрдүүлэн геологийн судалгаа, хайгуулыг эрчимжүүлж, уул уурхайн салбар дахь хөрөнгө оруулалтын суурь нөхцөлийг бэхжүүлж хайгуулын тусгай зөвшөөрөлтэй холбоотой үйл явцыг шуурхай, шударга, нээлттэй болох нөхцөлийг бүрдүүлнэ.

Боомтын шинэчлэл, тээвэр логистик: Хилийн боомтын дэд бүтцийг нэмэгдүүлэх хүрээнд хил дамнасан төмөр замуудын холболтыг эрчимжүүлж, боомтуудыг хатуу хучилттай авто замаар холбож, экспортыг нэмэгдүүлнэ. Мөн боомтуудыг иж бүрнээр өргөтгөх, бүтээн байгуулалтын ажлуудыг хэрэгжүүлнэ. Боомтуудад ухаалаг гарцыг бүрэн ашиглалтад оруулж, гаалийн бүрдүүлэлт, хяналтыг эрс хөнгөвчилж, боомтуудыг бүрэн цахимжуулна. Хил нэвтрэлтийн гаалийн хяналтын үйл ажиллагаа дахь хүний оролцоог бууруулж, хурдыг нэмэгдүүлэн тасралтгүй үйл ажиллагаа явуулах боломжийг бүрдүүлнэ.

Эрчим хүч: Либералчлалыг үргэлжлүүлэн хэрэгжүүлж, хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтыг татах чадвартай салбар болгон хөгжүүлнэ. Эрчим хүчний дамжуулах, түгээх сүлжээг шинэчлэн, алдагдлын хэмжээг бууруулж, дотоодын үйлдвэрлэлийг нэмэгдүүлснээр эрэлтийг хангаж, томоохон төслүүдийг хэрэгжүүлэхэд шаардлагатай дэд бүтцээр хангана. Цаашид сэргээгдэх эрчим хүчний салбарын хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтыг дэмжиж, нэмэгдүүлнэ.

Хөдөө аж ахуй: Хүнс, хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний гадаад худалдааг нээлттэй байлгаж, гадаад эрэлтийг нэмэгдүүлэхийн зэрэгцээ хөдөө аж ахуй, хүнс үйлдвэрлэлийн салбарын бодлогыг цогцоор нь шинэчилж, бие даасан хувийн

хэвшлийн оролцогчид бүхий зах зээл болж төлөвших үйл явцыг дэмжинэ. Цаашид, зах зээл, бизнесийн үйл ажиллагаанд нөлөөлөхүйц арга хэмжээг хэрэгжүүлэхийн өмнө үе шаттайгаар зогсоох стратеги (exit strategy)-ийг гаргасны үндсэн дээр батлах зарчмыг баримтална. Мөн аливаа бүтээгдэхүүний нөөц бүрдүүлэх (тухайлбал, мах) замаар үнийг хязгаарлах, үнэд нөлөөлөх төрлийн үйл ажиллагаанд төрөөс оролцохгүй байх зэргээр зах зээл дэх төрийн оролцоог бууруулна. Хөдөө аж ахуйн биржийн үйл ажиллагааг идэвхжүүлж хүнсний бүтээгдэхүүний нийлүүлэлтийн сувгийг нэмэгдүүлэх, малыг вакцинжуулах үйл ажиллагааг үр ашигтай зохион байгуулах, вакцинжуулалтын тогтолцоог сайжруулж малын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний экспортыг нэмэгдүүлэх боломжийг бүрдүүлнэ.

Аялал жуулчлал: Тус салбарыг татаас, дэмжлэгээс хараат бус, бие даасан, чөлөөт өрсөлдөөн бүхий, эдийн засгийн салбар болгох чиглэлд дэмжинэ. Аялал жуулчлалын бүх төрлийн үйлчилгээний чанар хүртээмжийг олон улсын стандартад нийцүүлж, салбарын өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх замаар жуулчдын тоог тогтвортой нэмэгдүүлэх бодлого баримтлан хэрэгжүүлнэ. Гадаад жуулчдын Монгол Улсад аялах визний шаардлагыг хөнгөвчилнө. Агаарын тээврийн либералчлалыг үргэлжлүүлэн хэрэгжүүлж, аялал жуулчлалын гол чиглэл, олон улсын авто замын дэд бүтцийн чанар, хүртээмжийг сайжруулж, аялал жуулчлалын авто зам дагуух үйлчилгээний цогцолбор, амрах талбайг нэмэгдүүлнэ. Нутгийн иргэдэд түшиглэсэн аялал жуулчлалын бүтээгдэхүүн, үйлчилгээг хөгжүүлэн, орлогыг нэмэгдүүлж, дөрвөн улирлын аялал жуулчлалын төлөвлөлтийг боловсруулна.

Шинжлэх ухаан: Хувийн хэвшлийн их сургууль, эрдэм шинжилгээний байгууллагатай хамтран хэрэгжүүлэх өндөр өгөөжтэй, зах зээлийн хэрэгцээнд нийцсэн судалгаа, хөгжүүлэлт, инновац болон гадаадын дэвшилтэт технологи нутагшуулах үйл ажиллагааг дэмжинэ. Ил тод, өрсөлдөөнт санхүүжилтийн тогтолцоог бүрдүүлж, хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтыг татах татварын болон санхүүгийн урамшууллыг ашиглана. Үр дүнг үйлдвэрлэл, үйлчилгээний салбарт нэвтрүүлж, нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн, үйлчилгээний үйлдвэрлэл, экспортын чадавхыг нэмэгдүүлнэ.

3.3. Төсвийн тусгай шаардлага хангасан байдал³

Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх хэсэгт заасны дагуу дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэл нь дараах төсвийн тусгай шаардлагуудыг хангаж байна.

Нэгдсэн төсвийн орлогыг тэнцвэржүүлсэн журмаар тооцдог байх. Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.3.а-д заасан шаардлагын дагуу зэс, нүүрсний үнийг тэнцвэржүүлсэн журмаар тооцсон бөгөөд 2026 онд зэсийн тэнцвэржүүлсэн үнийг тонн тутамд 8,341.8 ам.доллар, нүүрсний тэнцвэржүүлсэн үнийг тонн тутамд 133.7 ам.доллар байхаар тооцлоо.

³ Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн “12.3.9.төсвийн төлөвлөлтийн төсвийн тусгай шаардлагад нийцсэн байдал, дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэлээр тавигдсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд чиглэсэн байдал”

Нэгдсэн төсвийн суурь тэнцэл. Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.1 дэх хэсэгт нэгдсэн төсвийн суурь тэнцэл нь тухайн жилийн дотоодын нийт бүтээгдэхүүний хоёр буюу түүнээс дээш хувийн ашигтай байхаар заасан. Нэгдсэн төсвийн суурь тэнцлийн ДНБ-д эзлэх хэмжээ 2026 онд 2.0 хувьтай тэнцэж байгаа нь хуулийн шаардлагыг хангаж байна.

Хүснэгт 3.1 Нэгдсэн төсвийн суурь тэнцлийн төсөөлөл (ДНБ-д эзлэх хувь)

	2026	2027	2028
Хуулийн хязгаар	2.0%	2.0%	2.0%
Төсөөлөл	2.0%	2.0%	2.0%

Нэгдсэн төсвийн урсгал зарлагын хэмжээ. Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.3-т “нэгдсэн төсвийн урсгал зарлагын хэмжээ тухайн жилийн дотоодын нийт бүтээгдэхүүний 30 хувиас хэтрэхгүй байх” гэж заасан. Нэгдсэн төсвийн урсгал зарлагын дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хэмжээ 2026 онд 24.0 хувь, 2027 онд 23.0 хувь, 2028 онд 22.0 хувь байхаар тус тус төсөөлсөн нь төсвийн урсгал зарлагын дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хэмжээний тусгай шаардлагыг хангаж байна.

Засгийн газрын өрийн нэрлэсэн дүнгээр илэрхийлсэн үлдэгдэл. Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлд Засгийн газрын өрийн нэрлэсэн дүнгээр илэрхийлсэн үлдэгдэл нь тухайн жилийн ДНБ-ий 60 хувиас хэтрэхгүй байна гэж заасан. Засгийн газрын өрийн нэрлэсэн дүнгээр илэрхийлэгдсэн үлдэгдэл 2026-2028 онд хуулийн шаардлагыг хангаж байна.

Хүснэгт 3.2 Засгийн газрын өрийн нэрлэсэн дүнгээр илэрхийлсэн үлдэгдлийн төсөөлөл (ДНБ-д эзлэх хувь)

	2026	2027	2028
Хуулийн хязгаар	60.0%	60.0%	60.0%
Төсөөлөл	50.0%	45.0%	45.0%

3.4. Монгол Улсын нэгдсэн төсвийн 2026 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2027-2028 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл

Хүснэгт 3.3 Монгол Улсын нэгдсэн төсвийн 2026 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2027-2028 оны төсвийн төсөөллийн үзүүлэлт

Эдийн засгийн үндсэн үзүүлэлт	Төсвийн хүрээний мэдэгдэл	Төсвийн төсөөлөл	
	2026	2027	2028
1 Дотоодын нийт бүтээгдэхүүний бодит өсөлтийн хэмжээ /хувь/	5.7	6.3	6.5
2 Хэрэглээний үнийн өсөлтийн түвшин	7.0	6.0	5.0
3 Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлогын доод хэмжээ /тэрбум төгрөг/	31,930.0	33,761.0	37,299.3
ДНБ-д эзлэх хувь	31.2	29.3	28.2
4 Нэгдсэн төсвийн нийт зарлагын дээд хэмжээ /тэрбум төгрөг/	32,980.0	34,626.0	37,829.2
ДНБ-д эзлэх хувь	32.2	30.0	28.6
5 Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл /тэрбум төгрөг/	-1,050.0	-865.0	-529.9
ДНБ-д эзлэх хувь	-1.0	-0.8	-0.4
6 Нэгдсэн төсвийн суурь зарлагын дээд хэмжээ /тэрбум төгрөг/	29,859.1	31,452.6	33,254.6
ДНБ-д эзлэх хувь	29.2	27.3	25.1
7 Нэгдсэн төсвийн суурь тэнцэл /тэрбум төгрөг/	2,070.9	2,306.0	2,646.0
ДНБ-д эзлэх хувь	2.0	2.0	2.0
8 Засгийн газрын өрийн нийт хэмжээ /тэрбум төгрөг/	51,200.0	51,885.0	59,535.0
ДНБ-д эзлэх хувь	50.0	45.0	45.0
9 Нийгмийн халамжийн тухай хуульд заасны дагуу төсвөөс хуваарилах зардлын дээд хэмжээ /тэрбум төгрөг/	2,664.3	2,774.1	2,909.4
ДНБ-д эзлэх хувь	2.6	2.4	2.2

4. Дөрөвдүгээр бүлэг. Макро эдийн засгийн тулгарч болзошгүй эрсдэл

Нэг. Худалдааны дайн: АНУ-ын худалдааны бодлогын шийдвэрүүдтэй холбоотойгоор дэлхийн эдийн засагт тодорхой бус байдал эрчимтэй нэмэгдэж байна. АНУ-ын зүгээс худалдааны алдагдлыг бууруулах бодлогын хүрээнд бусад орнуудад тогтоосон тарифын хэмжээг нэмэгдүүлэх, дотоодын үйлдвэрлэлийг дэмжих зорилгоор зарим бараа бүтээгдэхүүнд онцгойлон өндөр тариф тогтоох зэрэг шийдвэрүүдийг гаргаад байна. Худалдааны дайны цар хүрээ улам бүр өргөжиж байгаа нь тодорхой бус байдлыг нэмэгдүүлж, дэлхийн эдийн засгийн идэвхжилийг хязгаарлах, инфляцыг өдөөх, бодлогын хүү удаан хугацаанд өндөр түвшинд хадгалагдах эрсдэлийг нэмэгдүүлж байна. Улмаар энэ нь манай улсын экспортын орлого буурах, инфляц өсөх, гадаад санхүүжилтийн өртөг, зардал нэмэгдэхэд нөлөөлж болзошгүй байна.

Хоёр. БНХАУ-ын эдийн засаг: БНХАУ-ын эдийн засагт үл хөдлөх салбарын уналт үргэлжилж, дотоод эрэлт сул хэвээр байна. БНХАУ-ын засгийн газраас эдийн засгийн өсөлтийг дэмжихэд чиглэсэн бодлогын арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлж байгаа хэдий ч худалдааны дайны хүрээнд АНУ-ын зүгээс БНХАУ-аас импортолж буй бүтээгдэхүүнд өндөр тариф тогтоосноор хоёр улс хоорондын худалдааны дайн хурцдаж, цаашид улам бүр тэлэх эрсдэлтэй байна. БНХАУ-ын эдийн засгийн өсөлт төсөөллөөс доогуур байх нь манай улсын экспортын орлогод сөргөөр нөлөөлж болзошгүй.

Гурав. ОХУ-Украины дайн, Ойрх Дорнодын нөхцөл байдал: ОХУ-Украины дайн, Израил, Иран улсуудын мөргөлдөөн зэрэг Ойрх Дорнодын тогтворгүй байдал даамжирч болзошгүй байгаа нь нефтийн бүтээгдэхүүний үнэ өсөх, инфляцын дарамт нэмэгдэх эрсдэлийг нэмэгдүүлж байна. Мөн ОХУ-ын эсрэг Европын холбоо, Их Британи болон АНУ зэрэг улсуудын авч хэрэгжүүлж буй хориг арга хэмжээ нэмэгдэх нь манай улсын гадаад төлбөр тооцоо саатах эрсдэлийг нэмэгдүүлж болзошгүй.

Дөрөв. Уур амьсгалын өөрчлөлт: Өвөлжилт, хаваржилтын нөхцөл байдал хүндэрсэнтэй холбоотойгоор хөдөө аж ахуйн салбар сүүлийн 2 жил дараалан агшаад байна. Цаг агаарын таагүй нөхцөл байдлаас өндөр хамааралтай хөдөө аж ахуйн салбарт хаваржилт хүндрэх, зуншлага тааруу байх зэргээр ган, зуд тохиох эрсдэл нэмэгдэх, малын халдварт өвчин тархах, газар тариалангийн гарц буурах зэрэг эрсдэл өндөр байна. Энэ нь хөдөө аж ахуйн салбарын үйлдвэрлэл, өрхүүдийн орлого буурах, орлогын тэгш бус байдал нэмэгдэх, дотоодын хүнсний инфляц нэмэгдэхэд нөлөөлж болзошгүй байна.

Тав. Эрчим хүчний тасалдал: Эрчим хүч нь эдийн засаг, нийгмийн тогтвортой байдлыг хангах суурь хүчин зүйл боловч манай улс дотоодын цахилгаан хүчний хэрэглээг бүрэн хангаж чадахгүй, 20 орчим хувийг хөрш орнуудаас худалдан авч хэрэглэж байна. Түүнчлэн Монгол Улсын эрчим хүчний үйлдвэрлэл өссөн нэмэгдэж буй хэрэглээг хангаж чадахгүй байгаагийн зэрэгцээ станцуудын насжилт өндөр, түгээлтийн шугам, тоног төхөөрөмжийн дийлэнх нь хуучирч, элэгдсэн эрсдэлтэй

нөхцөлд ажиллаж байна. Эрчим хүчний тасалдал нь бодит салбаруудын үйл ажиллагаа, нийт эдийн засгийн бүтээмжийг хязгаарлах эрсдэлтэй.

Зургаа. Зээлжих зэрэглэл буурах болон аливаа төрлийн хориг: Хөрш орнуудыг хамарсан геополитикийн хүндрэлтэй асуудлууд өрнөж буй энэ үед манай улс аливаа төрлийн хоригт өртөхгүй байх, зээлжих зэрэглэлийг сайжруулах хүрээнд олон улсад баримталж буй дүрэм журмуудыг мөрдөж, зээлжих зэрэглэл тогтоодог болон хориг арга хэмжээ авах эрх бүхий олон улсын байгууллагуудад хүргүүлэх холбогдох үнэлгээний тайлангуудыг сайтар бэлтгэх нь зүйтэй байна. Зээлжих зэрэглэл буурч, аливаа хоригт орсон тохиолдолд гадаадын хөрөнгө оруулалт, зээлийн урсгал буурах, төлбөр тооцоо саатах зэрэг эрсдэлүүд үүсэж болзошгүй.

5. Хавсралт

5.1. Олон нийтийн хэлэлцүүлгийн үр дүн

Санал ирүүлсэн байгууллага, иргэн	№	Ирүүлсэн санал	Тайлбар
Эрдэм шинжилгээний байгууллага	1	Алдагдалтай ажиллаж байгаа төрийн өмчит ААН, үйлдвэрийн газруудыг ангилж, засаглалыг ил тод болгож, хувьчлах.	Улсын хөгжлийн 2026 оны жилийн төлөвлөгөөнд туссан.
	2	Төсвийн зардлын ДНБ-д эзлэх хувийг 30 хувьд хүргэх шаардлагатай.	Дунд хугацаанд урсгал зардлын хэмжээг үе шаттай бууруулж, зах зээл дэх төрийн оролцоог бууруулах бодлого баримтална. Хуулийн төсөлд төсвийн урсгал зардлын хэмжээг 2026 онд ДНБ-ий 24 хувь, 2027 онд 23 хувь, 2028 22 хувь байхаар тусгасан.
	3	Урт хугацаанд бүтээмжээ дээшлүүлэх, эдийн засгаа тэлэх бодлогыг төсөвт тусгахад анхаарах.	Саналыг хүлээн авч, цаашид төсвийн хүрээний мэдэгдлийн төслийг боловсруулахад анхаарч ажиллана.
Төрийн байгууллага	4	Геополитикийн эрсдэл, тодорхой бус байдал өндөр байгаа үед гадаад эдийн засгийн нөхцөл байдлыг харгалзан үзэж, төсөөлөлд тусгах.	Саналыг хүлээн авч, Монгол Улсын нэгдсэн төсвийн 2026 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2027-2028 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд тусгав.
	5	Батлагдсан дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэлд олон удаа тодотгол хийх нь төсвийн сахилга бат, тогтвортой байдлыг алдагдуулах эрсдэлтэй.	Саналыг хүлээн авч, цаашид төсвийн хүрээний мэдэгдлийн төслийг боловсруулахад анхаарч ажиллана.
	6	ДХТХМ-д төсвийн алдагдлыг ДНБ-ий тодорхой хувьд барих зорилт тодорхой заах хэрэгтэй. Алдагдлыг бууруулахад чиглэсэн зардлын бүтцийн шинэчлэл, халамжийг оновчлох хөтөлбөрүүдийн хугацаа, шалгуур тодорхой байх нь маш чухал байна.	Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 19.9-д “төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл нь тухайн төсвийн жилийн дотоодын нийт бүтээгдэхүүний хоёр хувиас илүүгүй алдагдалтай, эсхүл ашигтай байна” гэж заасан. ДХТХМ боловсруулахдаа хуулийн шаардлагыг хангаж боловсруулав.
	7	Хэт өөдрөг төсөөлөхгүй байх, тэр дундаа орлогын төсөөллийг бодит байдалд нийцүүлэх	Саналыг хүлээн авч, цаашид төсвийн хүрээний мэдэгдлийн төслийг боловсруулахад анхаарч ажиллана.

Санал ирүүлсэн байгууллага, иргэн	№	Ирүүлсэн санал	Тайлбар
	8	Төсвийн зардлыг дахин нягталж, үргүй зардлыг бууруулж, төсвийн сахилга батыг холбогдох бүх түвшинд сахих.	Хуулийн төсөлд төсвийн нийт зардлын хэмжээг 2026 онд ДНБ-ий 32.2 хувь, 2027 онд 30.0 хувь, 2028 онд 28.6 хувь байхаар үе шаттай бууруулахаар хуулийн төсөлд тусгав. Төсвийн зардлын өсөлтийг ийнхүү хязгаарлаж байгаа нь төсвийн зарцуулалтыг үр ашгийг нэмэгдүүлэх, эрэлтийн гаралтай инфляцыг хязгаарлахад мөнгөний бодлоготой уялдах замаар дунд хугацаанд инфляцын зорилтот дүнг үе шаттай бууруулахад хувь нэмэр оруулна. Ингэснээр, ингэснээр дунд хугацаанд зээлийн хүү буурах, Засгийн газрын зээлжих зэрэглэл тогтвортой нэмэгдэх, төсвийн бодлогын орон зай бэхжих зэрэг чухал ач холбогдолтой.
Хувийн хэвшил	9	Түүхий эдийн зах зээлийн үнийг хэт өөдрөгөөр төсөөлөхөөс зайлсхийж илүү зөв, бодит, оновчтой тооцооллыг хийх.	Экспортын үнийн төсөөллийг түүхий эдийн эрэлт, нийлүүлэлтийн хандлага, эрчимтэй өрнөж буй гадаад зах зээлийн өөрчлөлтүүдийг харгалзан үзсэн олон улсын байгууллагуудын төсөөлөлд үндэслэн боловсруулж, анхны төсөөллөө бууруулсан болно. Түүхий эдийн үнийн төсөөлөл, зах зээлийн хандлагын талаар энэ танилцуулгын 3.1.2 дахь хэсгээс харах боломжтой.
	10	Мега төслүүдийн төсөв, санхүүжилтийн стратеги болон бусад мэдээллийг тодорхой болгох, төсөөлөлдөө оруулах.	Дунд хугацаанд хэрэгжих томоохон төслүүдийн нөлөөг дотоодын нийт бүтээгдэхүүний барилга, боловсруулах, эрчим хүч болон бусад салбарууд, гадаад худалдааны үзүүлэлтийн төсөөлөлд тусгаж, төслүүдийн эдийн засагт үзүүлэх нөлөөллийг салбар хоорондын тэнцэл болон хагас бүтцийн GAP шинжилгээгээр тооцоолон төсөөлөлд тусгасан болно.
	11	Ил тод байдлыг нэмэгдүүлэх.	Саналыг хүлээн авч, цаашид төсвийн хүрээний мэдэгдлийн төслийг боловсруулахад анхаарч ажиллана.
	12	Төсвийн орлого, бүрдүүлэгч татварын орлогод одоогийн татварын хуулийн шинэчлэл хэрхэн нөлөөлөхийг авч үзэх энэ тал дээр Сангийн яамтай хамтран ажиллах	Төсвийн тэнцвэржүүлсэн орлого болон нэрлэсэн ДНБ-ий харьцаа 2018, 2019 онуудад 29 хувь байсан бол 2023 онд 33 хувь, 2024 онд 37 хувь болж нэмэгдээд байна. Цаашид уг харьцааг 2026 онд 30.9 хувь, 2027 онд 29.3 хувь, 2028 онд 28.2 хувь болгох үе шаттай бууруулахаар хуулийн төсөлд тусгалаа. Ингэснээр хувийн хэвшлийг дэмжсэн татварын шинэчлэл хийгдэх орон зайг

Санал ирүүлсэн байгууллага, иргэн	№	Ирүүлсэн санал	Тайлбар
			бий болгож, хувийн хэвшлийн бизнесийн тэлэх боломжийг бүрдүүлэх, улмаар эдийн засаг дахь төрийн оролцоог үе шаттай бууруулна.
	13	Төсвөөс цалинждаг байгууллагууд болон төрийн захиргааны байгууллагуудын орон тоог багасгах, цахимд шилжүүлэх.	Дунд хугацаанд төрийн албан хаагчдын чиг үүргийн давхардлыг арилгаж, орон тоог бууруулж, халамжийн үйлчилгээг зорилтот бүлгийн нийгмийн баталгааг дээшлүүлэхэд чиглүүлэх, мөн тэтгэвэр, тэтгэмжийн хэмжээг зохистой түвшинд олгох ба төрийн үр ашиггүй зардлуудыг бууруулах бодлого баримталсан. Мөн урсгал зардлын хэмжээг үе шаттай бууруулж, зах зээл дэх төрийн оролцоог бууруулах бодлого баримталж ДХТХМ-ийг боловсруулав.
Иргэний нийгмийн байгууллагын төлөөлөл	14	Төсвийн хэт тэлсэн зардлаа бууруулах.	Дунд хугацаанд нийт зардлын ДНБ-д эзлэх хувь хэмжээг үе шаттай бууруулж, зах зээл дэх төрийн оролцоог бууруулах, нийгмийн халамжийн үйлчилгээг зөвхөн зорилтот бүлэг рүү чиглүүлэх, үр ашиггүй төсвийн зарцуулалтыг багасгаж төсвийн сахилга батыг сайжруулах бодлого баримтална.
Олон улсын байгууллага	15	Төсвийн орлого бүрдүүлэлтийг сайжруулах.	Саналыг хүлээн авч, цаашид төсвийн хүрээний мэдэгдлийн төслийг боловсруулахад анхаарч ажиллана.
Иргэн	16	Төсвийн сахилга батыг сайжруулах.	Дунд хугацаанд нийт зардлын ДНБ-д эзлэх хувь хэмжээг үе шаттай бууруулж, зах зээл дэх төрийн оролцоог бууруулах, нийгмийн халамжийн үйлчилгээг зөвхөн зорилтот бүлэг рүү чиглүүлэх, үр ашиггүй төсвийн зарцуулалтыг багасгаж төсвийн сахилга батыг сайжруулах бодлого баримтална.
	17	Татвар, нийгмийн даатгалын реформ хийх.	Дунд хугацаанд төсвийн тэнцвэржүүлсэн орлогын ДНБ-д эзлэх хувийг үе шаттай бууруулахаар хуулийн төсөлд тусгалаа. Ингэснээр хувийн хэвшлийг дэмжсэн татварын шинэчлэл хийгдэх орон зайг бий болгож, хувийн хэвшлийн бизнесийн тэлэх боломжийг бүрдүүлэх, улмаар эдийн засаг дахь төрийн оролцоог үе шаттай бууруулна.